

Иргэдийн нөхөрлөл байгуулах замаар байгалийн баялгийг хамгаалах, ашиглах

Олон нийтэд зориулсан гарын авлага



Иргэдийн
нөхөрлөл гэж
юу вэ?



Иргэд
байгалийн
баялагаа
хамгаалахад
нөхөрлөлийг
хэрхэн ашиглаж
болох вэ?



Иргэдийн
нөхөрлөлийг
ойлгох,
түүнийг хэрхэн
төлөвлөх,
байгуулах
талаарх гарын
авлага.

Товчилсон Үг

Байгаль Орчны Яам	БОЯ
Байгаль Орчныг Хамгаалах тухай Хууль	БОХТХ
Багийн Иргэдийн Нийтийн Хурал	БИНХ
Германы Техникийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг	ГТХАН
Дэлхийн Байгаль Хамгаалах Сан	ДБХС
Дэлхийн Унаган Байгаль Хамгаалахын төлөө Байгууллага	ДУБХБ
Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг	ЗАХН
Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр	НҮБХХ
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ИТХ
Нөхөрлөлийн Бүх Гишүүдийн Хурал	НБГХ
Ашигт Малтмал Газрын Тосны Хэрэг Эрхлэх Газар	АМГТХЭГ

Гарчиг

Өмнөх үг	2
Талархал	3
Гарын авлагын зорилго	4

Нэгдүгээр бүлэг: Иргэдийн нөхөрлөл	5
Иргэдийн нөхөрлөл байгуулах хууль зүйн үндэс	6
Нөхөрлөлийг хэрхэн байгуулах вэ?	6

Хоёрдугаар бүлэг: Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах	11
--	----

Гуравдугаар бүлэг: Нөхөрлөлийг удирдан зохион байгуулах	19
--	----

Дөрөвдүгээр бүлэг: Маргааныг шийдвэрлэх	25
---	----

Тавдугаар бүлэг: Байгаль орчны олон улсын гэрээ, конвенци	29
Дүгнэлт	32
Хавсралтууд	33

Өмнөх үг



Монгол орны байгаль орчин нь хүний үйл ажиллагаа болон цагаарын өөрчлөлтийн сөрөг нөлөөний улмаас маш хурдацтай доройтож байна. Сүүлийн жилүүдэд Монгол улсын цэвэр усны хангамж багасч, хотуудын агаарын бохирдлын түвшин ихэсч, цөлжилт газар авч, нийт нутгаар бэлчээрийн талхигдал явагдаж байна. Монгол орны байгалийн нөөцийн доройтол нь хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаа, газрын зохисгүй удирдлага, хууль бус мод бэлтгэл болон ан агнуур, хортой хаягдал бодисыг агаар болон усан хоолой руу хаях зэрэг хүний сөрөг үйл ажиллагааны үр дүн юм. Үүний зэрэгцээ хуулийн сул дорой хэрэгжилт нь эдгээр сөрөг ажиллагаануудын нөлөөг хэд дахин нэмэгдүүлж байна.

Монгол орны унаган байгалийг хэвээр хадгалахад олон хүндрэлтэй асуудлууд тулгарч байгаа боловч найдвар төрүүлэх сайн зүйлс бас байгаа юм. Байгаль

хамгаалах иргэдийн идэвхи улам сайжирч, олон хөдөлгөөн байгуулагдан байгаль хамгаалах үйл хэрэгт хувь нэмрээ оруулж байна. Монголчууд эх нутгаа хүндэлж хайрладаг ард түмэн бөгөөд хамгаас илүүтэйгээр газар нутгийнхаа унаган байдлыг хамгаалахыг хүсдэг. Эдгээр үндсэн үнэлэмжүүд нь Монгол улсын Үндсэн хууль болон бусад хуулиудад тусгагдсан байх бөгөөд байгалиа хамгаалах, хянах мөн түүний ашиг шимийг хүртэх, засгийн газраар дамжуулан байгаль орчны асуудалд оролцон хууль бус үйл ажиллагаанд саад учруулах эрхийг хангаж өгдөг.

Энэхүү гарын авлага нь олон нийтийн бүлгүүдэд суурилсан байгалийн нөөцийн менежментээр дамжуулан өөрийн нутгийн байгалийн нөөцийг хамгаалах болон ашиг шимийг хүртэх сонирхолтой нутгийн иргэдэд зориулагдсан чухал хэрэглэгдэхүүн юм. Гарын авлагад

нөхөрлөл хэрхэн байгуулах, байгалийн нөөцийг хамгаалах болон түүнийг зохион байгуулах төлөвлөгөөг хэрхэн боловсруулах, мөн нөхөрлөлийг хамтын менежментийн аргаар хэрхэн удирдах талаар тайлбарлав. Цаашилбал, энэхүү гарын авлага нь иргэдийн байгаль орчинтой холбоотой эрх, үүрэг, Монгол улсын нэгдэн орсон олон улсын холбогдох гэрээ конвенцүүдийн талаархи мэдээллийг агуулсан болно.

Энэхүү баримт нь байгалийн нөөцийг хамгаалах талаар мэдлэг олж авах сонирхолтой иргэд, төрийн бус байгууллагуудын гишүүд болон засгийн газрын тэргүүлэгчдэд байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэдийн нөхөрлөлийн талаар суурь мэдлэг өгөх зорилготой юм. Гарын авлага нь иргэдэд ерөнхий чиглэл өгөх боловч нөхөрлөлийг

удирдан зохион байгуулахад шаардлагатай (санхүүгийн тогтвортой байдал гэх мэт) чадавхийг хөгжүүлэх асуудлаар нарийн зааварчилгаа хангахгүй болно.

Энэ нь тус гарын авлагын анхны хэвлэл. Энэ гарын авлагыг иргэд хэрэгжүүлэн ашиглаж хэрхэн сайжруулах талаар саналаа бидэнд ирүүлснээр гарын авлага цаашид улам боловсронгуй болно гэдэгт Азийн сан найдаж байна. Та санал бодлоо wqmprogram@asiafound.mn хаягаар илгээнэ үү.

Гарын авлагыг Нидерландын Засгийн газрын тусламжаар Азийн сангийн хэрэгжүүлж байгаа тогтвортой хөгжиж ба байгаль орчныг хамгаалах санаачлага болох “Ирээдүйгээ баталгаажуулах нь” хөтөлбөрийн хүрээнд санхүүжүүлэн боловсруулав.

Талархал

Энэхүү гарын авлагыг гаргахад иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудыг төлөөлсөн олон хүн үнэтэй зөвлөлгөө өгч тусалсан бөгөөд байгууллага, хувь хүмүүстэй мэдээлэл солилцоходоо бид үргэлж баяртай байдаг юм. Бидэнд мэдээлэл, зөвлөгөө өгч тусалсан БОЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ц. Шийрэвдамба, газрын дарга А. Энхбат, ажилтан Э. Нэргүй; Их Хурлын Тамгын Газрын зөвлөх А. Мягмарсүрэн; ДБХС-гийн хөтөлбөрийн газрын захирал Б. Чимэд-Очир; ГТХАН-ийн төслийн зохицуулагч Ханс Хофман, төслийн ажилтан Тилмен Жагер; “Байгаль Хамгаалал” ДУБХБ-ын төслийн захирал Сюзан Антенен; Зэрлэг Амьтдыг

Хамгаалах Нийгэмлэгийн Монгол дахь Хөтөлбөрийн Захирал Аманда Файн, ажилтан Анн Винтерс; ДБХС-НУБХХ-ийн төслийн олон улсын техникийн зөвлөх Андрю Лоорий; Ариун суварга иргэний хөдөлгөөний тэргүүн Г. Чагнаадорж; Хөвсгөл далайн эзэд иргэний хөдөлгөөний тэргүүн Б. Баярмаа; Тосон Заамар иргэний хөдөлгөөний тэргүүн Д. Энхтөр нарын санал, мэдээлэл, зөвлөгөөг өндөрөөр үнэлж байна.

Оюунчимэг Цээсүрэн Финч гол зохиогчоор ажиллаж, Эдвард Делхаген хянаж, Азийн сангийн ажилтан Ц. Баярмаа хууль зүй бодлогын хүрээнд, У. Энхтүвшин захиргааны болон компьютерийн тал дээр гүн тусалцаа үзүүлэв.

Гарын авлагын зорилго

Энэхүү гарын авлага нь Монгол улсын Байгаль Орчныг Хамгаалах тухай Хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Монгол улсын байгалийн баялагийг хамгаалж хадгалж үлдэх сонирхолтой хүн бүрт иргэдийн нөхөрлөл хэрхэн байгуулах, удирдан явуулах талаар зааварчилгаа өгөх юм. Гарын авлагын бүлгүүдэд Монгол улсын Байгаль Орчныг Хамгаалах тухай Хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд иргэдийн эдлэх эрх үүрэг болон эдгээрийг ашиглан байгалийн нөөцийг хариуцлагатай ашиглаж амьжиргааны түвшингээ хэрхэн сайжруулахыг авч үзэх болно. Энэ зааварчилгаанд Монгол улсын нэгдэн орсон байгаль орчны олон улсын гэрээ, хэлэлцээр болон тэдгээрийн ач холбогдлын талаар өгүүлэв. Энэхүү гарын авлага нь доор дурдсан сэдвүүдийг хамрана. Үүнд:

- ◆ Байгаль орчны нөхөрлөлийн үйл ажиллагаа ба үндсэн зорилго.
- ◆ Нөхөрлөлийг хэрхэн байгуулах.
- ◆ Нөхөрлөлийн гишүүдийн нийтлэг эрх, үүрэг.
- ◆ Засаг дарга, нөхөрлөлийн үйл ажиллагаанд оролцогч эрх мэдэл бүхий төрийн ажилтны нийтлэг болон байгаль орчинтой холбоотой эрх, үүрэг.
- ◆ Байгалийн нөөцийг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах.
- ◆ Нөхөрлөлийг удирдан зохион байгуулах болон хамтын менежмент, хамтын төлөвлөлт ба иргэдийн оролцоотой үнэлгээний тухай ойлголт.
- ◆ Зөрчлийг шийдвэрлэх хандлагууд.
- ◆ Байгаль орчны нөхөрлөлийн үйл ажиллагатай холбоотой байгаль орчны олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийн товч таницуулага.

Энэхүү гарын авлага ий төрийн мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагууд олон улсын тусламжийн байгууллагууд болон Монгол улсын иргэний хөдөлгөөнүүдийн тэргүүлэгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага дээр үндэслэгдсэн болно. Тэдгээрийн санал бодол болон зөвлөмжүүд нь энэхүү гарын авлагын чиглэл болон боловсруулалтанд маш их хувь нэмэр оруулсан. Хуулийн үг хэллэгийг иргэдэд ойлгомжтой болгох үүднээс зарим хуулийн заалтуудын утгыг нь алдагдуулаагүйгээр үг хэллэгийг нь хябарчигсан болно.

Байгаль орчны нөхөрлөл гэж юу вэ?

Байгалийн нөөцийг хамгаалах, ашиглах иргэдийн нөхөрлөл нь (цаашид нөхөрлөл гэнэ) Монголын Засгийн газраас албан ёсоор зөвшөөрөгдсөн, тодорхой хэмжээний газар, байгалийн нөөцийг гэрээгээр тодорхой хугацаанд эзэмших эрхтэй хуулийн этгээд юм.

1

ИРГЭДИЙН НӨХӨРЛӨЛ



Монгол улсын хуулийн дагуу нөхөрлөл байгуулах үндсэн зорилго нь биологийн төрөл зүйлийг хамгаалах, хүрээлэн байгаа орчны экологийн тэнцвэрийг хадгалах, хариуцан авсан газар нутагтаа ой, амьтан, ургамал гэх мэт байгалийн нөөцийг нэмэгдүүлэхэд оршино. Жишээлбэл, нөхөрлөлүүд нь самар, жимс, эмийн ургамал түүх, зөвшөөрөгдсөн амьтан агнах гэх мэт байгалийн нөөцийг ашиглах эрхтэй боловч бас тэдгээрийг хамгаалах, үржүүлэх үүрэгтэй. Гэвч ямар байгалийн нөөцийг, хэрхэн ашиглах тухай хязгаарлалтууд байж болно. Нөхөрлөлүүд байгалийн нөөцийг ашиглахдаа Монгол улсын байгаль орчныг хамгаалах холбогдох хууль, дүрмийг хатуу мөрдөнө. Тухайлбал, Монгол улсын хуулиар нөхөрлөл нь усны нөөц (гол, мөрөн, нуур гэх мэт), бэлчээрийг гэрээгээр хувьчлан авч болохгүй юм.

Нөхөрлөлийг сайн дурын үндсэн дээр байгуулна. Хуулиар хүн бүрийг нөхөрлөлийн гишүүн байхыг шаардахгүй бөгөөд зөвхөн гишүүн болох эрхийг нь хангадаг юм. Нөхөрлөлийн гишүүн 18 нас хүрсэн, тухайн сум дүүргийн харъяат, мөн сум, дүүрэгтэй байнга оршин суугч Монгол улсын иргэн байна. Нөхөрлөлийн гишүүдийн тоо хангайн бүсэд 30 хүн буюу 15 өрхөөс дээш, говь хээрийн бүсэд 20 хүн буюу 10 өрхөөс дээш байна.

Нэг нөхөрлөлийн хариуцан хамгаалах байгалийн нөөц бүхий газар нь хангайн бүсэд 6,000 хүртэл га, говийн бүсэд 10,000 хүртэл га газар байна. Энэ хэмжээнээс илүү газрыг хариуцан хамгаалах хүсэлтэй нөхөрлөл нь аймаг, нийслэлийн байгаль орчны албаны саналын үндсэн дээр асуудлыг сум, дүүргийн ИТХ-аар шийдвэрлүүнэ.

Хариуцан хамгаалж байгаа газраа тэмдэглүүлж, хадлангийн талбай болон туршилт, судалгаа, нөхөн сэргээлт хийх газрыг хашиж хамгаалж болно. Харин

иргэдийн чөлөөтэй нэвтрэх, аялал жуучлал хийх боломж болон амьтдын нүүдлийг хаах: зам, гарам боох, таглах: голын голдирылыг өөрчлөх зэргийг хориглоно. Нөхөрлөлийн эрх, үүргийн талаар дэлгэрэнгүйг хавсралтаас харж болно.

Иргэдийн нөхөрлөл байгуулах хууль зүйн үндэс

Монгол улсын Үндсэн хууль болон Байгаль орчныг хамгаалах хуулиар иргэдэд хэд хэдэн төрлийн эрхүүд олгогдсон байдаг. Эдгээр эрх нь улс орны урт хугацааны сайн сайхан байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх байгаль орчныг хамгаалах үндэс суурийг бий болгоно. Доор Монгол Улсын Байгаль Орчныг Хамгаалах Тухай Хуульд заасан Монгол улсын иргэний эрхийг тусгасан болно. Үүнд:

- ◆ Иргэн байгаль орчныг хамгаалах төрийн бус байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх эрхтэй. Мөн нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялагийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх эрхтэй. (1-р бүлэг, 4.1.3-р зүйл)
- ◆ Хуулинд өөрөөр заагаагүй бол Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллага, гадаадын иргэн, хуулийн этгээд нь байгалийн баялагийг зохих төлбөр, хураамжийг төлж гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно. (1-р бүлэг, 6.2-р зүйл)
- ◆ Төр түүний байгууллага, албан тушаалтан нь нөхөрлөлд гэрээний дагуу байгалийн тодорхой төрлийн

баялгийн хамгаалалт, ашиглаалт, эзэмшилтийг хариуцуулах хэлбэрээр байгаль орчныг хамгаална. (4-р бүлэг, 19.2.7-р зүйл)

- ◆ Иргэдийн нөхөрлөл байгуулах эрх нь Байгаль Орчныг Хамгаалах Тухай Хуульд зааснаас гадна бусад хуулиудаар бас олгогдсон байна. Орон нутгийн иргэд уул уурхайтай холбогдолтой шийдвэрт оролцох, уурхайн үйл ажиллагааг хянах эрхүүдээр мөн хангагдсан. Иргэдийн нөхөрлөл нь үйл ажиллагаагаа Байгаль Орчны Сайдын 2006 оны 4 сарын 26-ны өдрийн 114 тушаалын хавсралт журмын дагуу явуулна.

Нөхөрлөлийг хэрхэн байгуулах вэ?

Нөхөрлөл байгуулах нь шинэ аж ахуйн нэгж байгуулах үйл явц бөгөөд иргэд, төрийн эрх бүхий байгууллагын ажилтнуудын хамтын ажиллагааны үр дүн байна. Энэхүү хуулийн дагуу бүртгэгдсэн аж ахуйн нэгж нь байгалийн нөөцийг арчлан хамгаалах, үржүүлэх үүрэгтэй. Доор тайлбарласан шатлалууд нь иргэдэд нөхөрлөл байгуулах үйл ажиллагаагаа зохион байгуулахад нь туслах бөгөөд мэдээж нөхөрлөл байгуулагч этгээд энд зааснаас өөр арга замыг сонгож болно.

Үе шат 1. Иргэд нөхөрлөлийн талаар ойлгох

Нөхөрлөл байгуулах анхны алхам бол баг, сумын иргэд нөхөрлөл болон түүнийг байгуулах зорилгын талаар ойлгох явдал юм. Хариуцан авсан газар нутгийнхаа байгалийн нөөцийг хэрхэн хамгаалах, өсгөх, түүнийг зохистой ашигласнаар аж амьдралаа дээшлүүлэхэд ямар зохион

байгуулалттай ажиллах талаар мэдэх хэрэгтэй болно. Энэ нь нөхөрлөл байгуулах зорилгод нийцэж байгаа юм.

Тодорхой газар нутгийг хамгаалж, байгалийн баялагийг нь ашиглах зорилгоор нөхөрлөл байгуулах сонирхолтой иргэд цугларч хоорондоо өөрсдийн хэрэгцээ, сонирхлын талаар ярилцах хэрэгтэй. Анхны цуглаанаар нөхөрлөлийн тухай ойлголт, яагаад нөхөрлөл хэлбэрээр байгуулагдах нь тухайн олон нийтийн бүлэгт тохиромжтой болох, өөр ямар хувилбарууд байж болох болон нөхөрлөлийг байгуулах явцад хэн оролцох талаар ярилцаж шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл олж авах явдал чухал юм. Энэ нь нөхөрлөлийг байгуулах үйл явц дээр хамтран ажиллах анхны үе шат болно.

Үе шаг 2. Нөхөрлөлийн нийтлэг эрх, үүргийг ойлгох

Нөхөрлөлийн эрх, үүрэг нь хуулиар тодорхойлогдсон байх ба үүнд:

Эрх:

- ◆ Байгалийн тухайн нөөц баялагийг ашиглах талаар шийдвэр гаргахад оролцох, төрийн зохих шатны байгууллагуудаас дэмжлэг, тусалцаа авах, нутгийн иргэдийг байгаль хамгаалах үйл ажиллагаанд өргөнөөр оролцуулах
- ◆ Гэрээгээр заасан газар, нутаг, байгалийн нөөцийг хариуцан хамгаалах, байгалийн нөөцийн дагалт баялаг (самар, жимс, эмийн ургамал, амьтан гэх мэт) бусад тогтвортой үр өгөөжийг хүртэх, ашиглах
- ◆ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх дундын сан бүрдүүлэх



- ◆ Хууль тогтоомж, хяналт, гэрээ, байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд өөрийн хариуцан хамгаалах байгалийн нөөц баялгийн экосистемийн даацад тохируулан зохих төлбөр, хураамжтайгаар зохистой ашиглах
- ◆ Сум, дүүргийн засаг дарга болон байгаль орчны хяналтын агентлагтай хамтран ажиллаж, хариуцсан газар нутаг дэх экосистемд сөргөөр нөлөөлж буй хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох

Үүрэг:

- ◆ Тухайн хариуцан хамгаалж байгаа орчны ой, ус, ургамал, амьтан, байгалийн бусад баялагийг хамгаалах, нөөцийг нь хомсдохоос сэргийлэх арга хэмжээ авах
- ◆ Нөхөрлөлийн гишүүдийн санал бодол болон сонирхолыг нөхөрлөлийг хөгжүүлэх шийдвэрүүдэд тусгах
- ◆ Байгалийн баялагийг ашиглаж олсон орлогын 30-аас доошгүй хувийг дундын санд шилжүүлж, тухайн байгалийн нөөцийг хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулах
- ◆ Хүрээлэн буй орчны экосистемд явагдаж буй өөрчлөлтүүдийг хянаж ажиглах ба экосистем болон ан амьтдад сөрөг өөрчлөлтүүд гарсан, ямар нэгэн хууль бус үйл ажиллагаа илрүүлсэн тохиолдолд байгаль орчны байцаагч, хамгаалагчид мэдээлж байх
- ◆ Байгалийн нөөцөд хохирол учирсан тохиолдолд холбогдох төрийн агенлагуудад хандах мөн тэдгээрийг нөхөн сэргээх арга хэмжээ авахыг шаардах; хохирол бусдын буруутай үйл ажиллагааны улмаас бий болсон бол нөхөрлөлийн гишүүдэд нөхөн олговор олгоно

Үе шат 3: Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах

Ямар ч нөхөрлөлийн хамгийн гол анхаарах асуудал бол Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг (БНМТ) боловсруулж, мөрдөх явдал юм. Нөхөрлөл байгалийн нөөц ашиглалтанд тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг тул гишүүд хариуцан авсан газар нутгийнхаа байгалийн нөөц баялагийг хэрхэн ашиглах болон улмаар тухайн газар нутагт ямар өөрчлөлт гарах талаар бодолцох хэрэгтэй.

Нөхөрлөл байгуулах үе шат

1. Иргэд нөхөрлөлийн талаар ойлгох
2. Нөхөрлөлийн нийтлэг эрх ба үүргийг ойлгох
3. Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулах
4. Нөхөрлөлийг байгуулах
5. Өргөдөл гаргах, гэрээ байгуулах
6. Нөхөрлөлийг цуцлах

Энэ төлөвлөгөө нь нөхөрлөл байгуулахад шаардагдах бичиг баримтуудын нэг юм. Төлөвлөгөөнд хариуцан авсан газар нутгийн талаарх мэдээлэл, байгалийн нөөцийн ерөнхий байдал (үнэлгээ гэнэ) болон байгалийн нөөцийг хэрхэн хамгаалах, арвижуулах, түүний үр ашгийг хүртэх үйл ажиллагаануудыг тодорхой тусгасан байх шаардлагатай. БНМТ-г боловсруулах талаар Хоёрдугаар бүлэгт дэлгэрэнгүй үзүүлэв.

Үе шат 4. Нөхөрлөлийг байгуулах

Иргэд нь нөхөрлөл байгуулах нь үр ашигтай гэж зөвшөөрсөний үндсэн дээр нөхөрлөл цаашид ямар үйл ажиллагаа явуулах талаар саналаа боловсруулна. Энэ саналд нөхөрлөлийн гишүүдийн талаарх ерөнхий мэдээлэл, тухайн хариуцан авч байгаа газрыг хэрхэн ашиглах, энэ нь тухайн газар нутагт яагаад тохиромжтой болохыг тайлбарлах хэрэгтэй.

Сайн дурын үндсэн дээр иргэд байгалийн нөөцийг хариуцан хамгаалж, ашиглах нөхөрлөл байгуулах олонхийн шийдвэрээ гаргаж саналаа баг, хорооны засаг даргад хүргэнэ. Нөхөрлөл байгуулах

саналыг хүлээн авсан баг, хорооны засаг дарга 15 хоногт багтаан баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурлаар (ИНХ) хэлэлцүүлж дүгнэлт гаргууна. Баг, хорооны засаг дарга ИТХ шийдвэрээ зохих цаг хугацаанд гаргахыг хянаж баталгаажууна. Нөхөрлөл байгуулах хүсэлтэй иргэдийн төлөөлөгч гаргасан дүгнэлтийг сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын (ИТХ) тэргүүлэгчдэд 7 хоногийн дотор уламжилна. Сум, дүүргийн ИТХ нь санал хүлээж авснаас хойш 14 хоногт багтаан асуудлыг шийдвэрлэнэ.

Үе шаг 5. Өргөдөл гаргах, гэрээ байгуулах

Баг, сумын ИТХ-аар зөвшөөрөгдсөн тохиолдолд нөхөрлөл байгуулах хүсэлтэй иргэд өргөдлөө Хавсралт 1-т заасан бичиг баримтуудын хамт сум, дүүргийн засаг даргад өргөн барина. Сум, дүүргийн засаг дарга нь иргэдээс нөхөрлөл байгуулах өргөдөл, шаардлагатай бичиг баримтуудыг хүлээж авсны дараа 10 хоногийн дотор хариу өгч, дэмжсэн нөхцөлд нөхөрлөлийн эрх бүхий төлөөлөгчтэй гэрээ байгуулна. (Хавсралт 2-т Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээний загварыг үзүүлэв.)

Гэрээнд дараахь зүйлсийг тусгана.

Үүнд:

- ◆ Нөхөрлөлийн гишүүдийн нэрс.
- ◆ Эзэмшүүлж байгаа байгалийн баялгийн нөөц, тэдгээрийг ямар зорилгоор ашиглах болон хариуцан авах газар нутгийн байршил.
- ◆ Нөхөрлөл байгуулах болсон үндэслэл, нөхөрлөлийн зорилго болон үйл ажиллагаа явуулах хугацаа.
- ◆ Байгаль хамгаалах үйл ажиллагааны хөтөлбөр, менежментийн төлөвлөгөө

менежментийн төлөвлөгөөг биелүүлээгүй тохиолдолд төлөх торгууль болон бусад хөлс, хохирлыг нөхөн төлүүлэх хэлбэр, учруулсан хохирлыг үнэлэх бусад үйл явц.

- ◆ Талуудын тохиролцсон бусад асуудал.

Үе шаг 6. Нөхөрлөлийг цуцлах

Зарим тохиолдолд янз бүрийн шалтгаанаар орон нутгийн иргэд нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоох нь зүйтэй гэж үзэж болно. Түүнчлэн сум, дүүргийн засаг дарга нөхөрлөлтэй байгуулсан гэрээгээ цуцлах эрх мэдэлтэй байна. Дараахь нь нөхөрлөлийн хуулийн статусыг цуцлах үндэслэл болно:

- ◆ Баг, хорооны ИНХ нөхөрлөлийн хуулийн статусыг цуцлахыг шаардсан эсвэл сум, дүүргийн ИТХ нөхөрлөлийн үйл ажиллагааг хориглох шийдвэр гарсан. Энэ хоёр тохиолдолд засгийн газрын агентлаг нь ойлгомжтой ил тод шалтгаанаар нөхөрлөлийг цуцлана.
- ◆ Гэрээнд заагдсан үүргээ удаа дараа биелүүлээгүй, гэрээнд гарын үсэг зурснаас хойш 6 сарын дотор гэрээнд заагдсан байгаль хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлээгүй.
- ◆ Тухайн орон нутгийн оршин суугчдын дийлэнх нь нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргасан.
- ◆ Нөхөрлөлийг байгуулахдаа холбогдох хууль журмыг мөрдлөг болгоогүй.

Өдөр тутмын амьдралынхаа явцад эх нутгаа ажиглах замаар орон нутгийн иргэд байгаль орчны талаар нилээд их мэдлэг олж авсан байдаг. Байгаль орчноо хамгаалах уламжлалт аргууд нь сайн байгалийн нөөц хадгалалт болон болон удирдалагын төлөвлөгөөг боловсруулан хөгжүүлэхэд үндсэн суурь эх сурвалж нь болдог.



2

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ



Байгаль орчны хуулийн дагуу нөхөрлөл байгуулан ажиллах үйл ажиллагааны үндсэн зорилг нь тухайн нутаг дэвсгэрт орших биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн тэнцвэр, төрх байдлыг хадгалах, ой мод, ургамлын нөөцийг арвижуулах гэх мэтээр хариуцан авсан тодорхой байгалийн нөөцийг арчлан хамгаалахад оршино. Ингэхийн тулд нөхөрлөлийн гишүүд Байгалийн Нөөцийн Менежментийн Төлөвлөгөөг боловсруулах ёстой. Ийм төлөвлөгөө нь байгалийн нөөцийг зохистойгоор, тухайн нутгийн экологийн тэнцвэрийг алдагуулаагүйгээр ашиглах, орон нутгийн иргэдийн амьдралыг сайжруулахад тусална.

Энэ бүдэлт БНМТ-нд юу орох, тодорхой үйл ажиллагаануудыг хэзээ, хэрхэн, хэн гүйцэтгэхийг авч үзнэ. Мөн менежментийн төлөвлөгөөний үр дүнд ямар амжилтанд хүрч болох талаар жишээ татаж үзүүлнэ.

Нөхөрлөлийн амжилт нь байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэр сайн боловсруулж хэрэгжүүлсэнээс ихээхэн хамаарна. Байгалийн нөөцийн менежментийн сайн төлөвлөгөө боловсруулахын тулд иргэд тухайн хариуцан авсан газар нутгийн байгаль орчны баялаг, орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлага, тухайн байгалийн нөөцөд учирч буй аюул занал болон тэдгээр аюул заналын эх үүсвэрийн талаар ойлгосон байх шаардлагатай. Түүнчлэн иргэд хариуцан авсан газар нутгийн нөөц баялагийг ашигласнаас эсвэл бусад хүчин зүйлсийн үр дүнд тухайн экосистемд учирч буй эсвэл учирч болзошгүй аюул заналын талаар мэдэж байвал зохино.

Орон нутгийн иргэд тухайн экосистемд бий болж буй өөрчлөлтүүдийг өдөр тутмын амьдралын явцад байнга ажиглах замаар байгаль орчны талаар ихээхэн мэдлэг туршлагатай болдог. Эдгээр орон нутгийн иргэдийн байгаль орчныг

хамгаалах уламжлалт арга замууд нь байгалийн нөөцийг арчлан хамгаалах сайн төлөвлөгөө боловсруулан гаргахад үндсэн давуу тал болох бөгөөд энэхүү уламжлагдан ирсэн мэдлэгийг төлөвлөгөө боловсруулахдаа зохион байгуулж, ашиглах хэрэгтэй юм.

Мэдээжээр, БНМТ нь бүс, нутаг бүрт өөр өөр байж болох ба энэхүү бүлэгт төлөвлөгөөг боловсруулах ерөнхий зарчмын талаар тайлбарлаж, иргэдэд санаа өгөх зорилгоор төлөвлөгөөг боловсруулахад хэрэгтэй асуултаудыг ороулж өгөв.

Хариуцан авсан газар нутгийн экосистемийг ойлгох

Байгалийн нөөцийг хамгаалах, арчлах, түүнд ажиглалт хийхийн тулд нөхөрлөлийн гишүүд нь хуулийн дагуу хариуцан авч буй газар нутгийн экосистемийн талаар дэлгэрэнгүй ойлголттой байх шаардлагатай.

Дээр дурдсанчлан орон нутгийн иргэд өөрийн нутаг орны экосистемийн талаар сайн мэддэг, байгаль хамгаалах уламжлалт аргыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлсээр ирсэн байдаг. Тийм учраас нөхөрлөлд хамтрах сонирхолтой иргэд өөрийн нутгийн байгалийн талаарх мэдлэгээ хуваалцаж, харилцан ярицаж ямар үйл ажиллагаагаар түүнийг арвижуулан ашиглаж болох талаар ярилцах хэрэгтэй. Газрын зураг боловсруулахад нөхөрлөлийн бүх гишүүд оролцвол илүү үр дүнтэй болно.

Зураг 1. Баянхангай нөхөрлөлийн бүүдүвч зураг байгуулах дасгал



Эх үүсвэр: Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгээс зохион байгуулсан семинарын тайлан, Монгол улс, 2007.

Зураг 1, 2-т Баянхангай нөхөрлөлийн боловсруулан гаргасан газрын зургийг жишээ болгон үзүүлэв.

Баянхангай нөхөрлөл нь хариуцан авсан газар нутгийн байгаль орчны болон нийгмийн үзүүлэлтүүдийг харуулахдаа Зураг 2-т үзүүлсэн тэмдэглэгээг ашигласан байна. Нөхөрлөлийн гишүүд өөрсдөө тэмдэглэгээгээ зураглан зохиож болно.

Нөхөрлөлийн удирдлага нь хариуцан авсан газар нутгийн амьтан, ургамлын төрөл зүйлс, тухайн газар нутгийн ойн экосистем, нуур, гол мөрний талаарх үндсэн мэдлэг, мэдээллийг нөхөрлөлийн иргэдэд олгох үүрэгтэй. Ийм мэдлэг мэдээлэл нь нөхөрлөлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх байдалд байгаль орчны суурь үнэлгээг хийхэд хэрэгтэй бөгөөд энэхүү үнэлгээн дээр үндэслэн цаашдын бүх үйл ажиллагаа төлөвлөгдөх болно. Хэрэв нөхөрлөлийн тэргүүн өөрийн хариуцан авсан газар нутгийн талаарх мэдээллийг тайлбарлахад тусалцаа хэрэгтэй гэж үзвэл сумын байгаль орчны мэргэжилтэн, хяналтын байцаагч нараас тусламж хүсэх мөн сум болон аймгийн засаг даргын тамгын газраас ийм төрлийн үнэлгээ хэрхэн хийх талаар сургалт явуулах хүсэлт тавьж болно. Байгаль орчны мэргэжилтэн болон байцаагч нар нь орон нутгийн иргэдэд дээр дурьдсан үйлчилгээг үзүүлэх үүрэг албан ёсоор хүлээдэг юм.

Доорх асуудлууд нь нөхөрлөлийн гишүүдийн хурлаар байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэлэлцэхэд хэрэгтэй байж болно. Үүнд:

Тухайн газар нутгийн талаарх ерөнхий ойлголт:

- ◆ Тухайн газар нутгийн байршил? Тухайн газар нутгийн гүүх? Ямар хүмүүс амьдардаг? Ямар хүмүүс амьдарч байсан?

*	Сумын Төв
∩	Өвөлжөө
□	Хаваржаа
△	Хадлангийн талбай
+◇	Зуслан
+□	Намаржаа
×	Тарвага /Ичээ/
○	Бор гөрөөс
●	Нутгийн цагаан зээр
▲	Нүүдлийн цагаан зээр
■	Цагаан зээр төллөх газар
∩	Булаг болон жижиг гол
⌚	Гар худаг
Φ	Хайлаасан төгөл
У	Моносны төгөл
М	Чоно
∅	Үнэг
R	Хярс
V	Үлийн цагаан оготно
◇	Хамгаалсан худаг
≡	Түймэрт өртөмтгий газар
÷	"Эв нэгдлийн" өргөө
Λ	Өндөрлөг газар
T	Махчин шувуудын суудал, үүр
⊕	Моторт худаг
Г	Зэрлэг гахай
У	Хусан төгөл
0	Нуур
	Шувуу
-	Зам
ногоо	Ногооны талбай

Зураг 2. Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэгээс зохион байгуулсан "Байгалийн нөөц баялагийг нөхөрлөлд эзэмшүүлэн хамгаалах арга зам" сэдэвт семинарт оролцсон нөхөрлөлүүдийн гаргасан газрын зургийн тэмдэглэгээ.

"Байгалийн нөөц баялагийг малчдын нөхөрлөлд эзэмшүүлэн хамгаалах арга зам" семинарын тайлан, ЗАХН, Монгол улс 2007

Хүснэгт 1. Байгаль орчин, нийгмийн зарим асуудлууд болон тэдгээрийн үзүүлэлт, шалтгаанууд.

Асуудал	Үзүүлэлт	Шалтгаан
Бэлчээрийн газрын доройто	Хөрсний эвдрэл, ургамлан бүрхүүлийн багасалт, малын эрүүл мэндийн асуудлууд	<ul style="list-style-type: none"> Бэлчээрийн даацын хэтрүүлэлт, малын бүрэлдэхүүний өөрчлөлт болон уламжлалт мал аж ахуй, удаа дараалаасан ган гачиг, хавар болон намрын хүчтэй салхи, шороон шуурга, гадаргын усны гачигдал/ хомсдол. Хөдөө аж ахуйн бүс нутаг, уул уурхайн үйлдвэрлийн хөгжил тээлт, тэр дундаа хүн ам суурьшсан газар болон усны цэгүүдийн эргэн тойронд өрнөж буй хурдацтай өсөлтийн нөлөө
Хөрсний эвдрэл	—	<ul style="list-style-type: none"> Малын өсөлт, ган, гадаргын усны хомсдол, хариуцлаггүй уул уурхайн үйл ажиллагаа, хангалтгүй нөхөн сэргээлт
Гадаргын усны хомсдол/ дутагдал, гадаргын усны бохирдол	Ус ширгэн алга болох буюу урсгал нь тасалдах, голын загас, амьтад үгүй болох, усны эх, ундарга нь бохирдсон	<ul style="list-style-type: none"> Орон нутгийн голын системийн , хүн болон амьтны нөлөөллөөс болж голын эрэг сүйтэх Уурхайн газрууд болон бусад аж ахуйн нэгжүүдээс химийн хорт бодисын хаягдал ялгаруулах Гэр аж ахуйн, хүний болон малын хог хаягдлыг гол, голын цутгалан руу хяналтгүйгээр юүлэх
Үйл ажиллагаатай худагийн хомсдол	Хаягдсан, эвдэрсэн худаг	<ul style="list-style-type: none"> Худагийн эзэмшил гэж байдаггүй, санхүүгийн туслаацаа, дэмжлэг хомс
Ой хээрийн гал түймэр	Ой хээрийн гал түймрийн ихсэлт	<ul style="list-style-type: none"> Санамсар/ болгоомжгүй хүний үйл ажиллагаа, ган гачиг болон хуурай уур амьсгалын улмаас илүү их газар авах, нэмэгдэх; байгаль орчны шинжээчдийн дутагдалтай болон чадамж муутай байдал, бага/ хангалтгүй төсөв, багаж хэрэгслийн дутагдал

- ◆ Тухайн нутаг дэвсгэрт ямар байгалийн нөөц баялаг байна вэ? Энэ нутагт төмрийн эсвэл ашигт малтмлын нөөц баялаг, ой мод, малын бэлчээр, ус, ан амьтан, ургамал, байгалийн үзэсгэлэнт газар болон бусад зүйл байна уу?
- ◆ Энэ газар нутгийн экосистемийн ерөнхий хэв шинж ямар байна вэ? (Уулархаг, тал нутаг, цөлөрхөг, устай гэх мэт)
- ◆ Энэ нутгийн цаг агаар ямар вэ? Цаг

- агаарын өөрчлөлт явагдаж байна уу? Хэрэв тийм бол таны бодлоор тухайн нутгийн экосистем хэрхэн даган өөрчлөгдөх вэ? Нөхөрлөл нь цаг агаарын өөрчлөлтийн явцад экологийн тэнцвэрийг алдагдуулахгүй байхад хэрхэн хувь нэмэр оруулж болох вэ?
- ◆ Яагаад энэ газар нутгийг хамгаалах шаардлагатай байна вэ? Яг юут чухалчлан хамгаалах хэрэгтэй байна

Хүснэгт 1 үргэлжлэл

Асуудал	Үзүүлэлт	Шалтгаан
Ойн өвчлөл	Үхсэн болон үхэж буй моднууд, ой модны чанарын бууралт	<ul style="list-style-type: none"> Ойн цэвэрлэгээ хийгддэггүй, иргэд ой цэвэрлэх талаар мэдлэг мэдээллээр хомс байдаг, Байгаль хамгаалагч болон байгаль орчны шинжээчдийн дутагдалтай болон чадамж муутай байдал, хангалтгүй төсөв төлөвлөлт
Зэрлэг амьтдын тоо толгойн бууралт	Зэрлэг амьтад маш ховор харагдах болсон	<ul style="list-style-type: none"> Амьдрах орчны доройтол, зэрлэг амьтдын хоол тэжээлийн дутагдал, ан агнуур, цаг агаарын болон байгалийн бусад гамшиг Аялал жуулчлал, уул уурхай, хөгжил зэрэгтэй холбоотой хүний үйл ажиллагаанаас үүдэн зэрлэг амьтад ховордох болсон
Тарвагын тоо толгойн бууралт	—	<ul style="list-style-type: none"> Тарвагны арьс, махыг ашиглах зорилгоор тарвага агнах нь ихэссэн, амьдрах орчны доройтол
Хууль бус мод бэлтгэл	Ой модны сүйрэл, доройтол	<ul style="list-style-type: none"> Хуулийн хэрэгжилт муу, иргэдийн мэдээлэл муутай болон ойн удирдлага, түлээний мод бэлтгэлийн талаарх сургалт, семинарын дутагдалтай байдал
Малын хулгай	—	<ul style="list-style-type: none"> Хөдөө орон нутаг дахь ядуурлын өсөлт, хангалтгүй хуулийн хэрэгжилт болон хяналт, туршлаггүй малчдын өсөн нэмэгдэж буй тоо хэмжээ
Мал сүргийн чанарын бууралт	Мал сүргийн чанарын бууралт	<ul style="list-style-type: none"> Ноолуурын өндөр үнэ (өсөн нэмэгдэж буй зах зээлийн урамшуулал), мал сүрэг дэх ямааны тоо толгойн өсөлт, мал сүргийн бүрэлдэхүүний зохицуулалт байхгүй, засгийн газрын бодлого болон хэрэгжилтийн дутагдалтай байдал, уламжлалт мал аж ахуйн талаарх мэдлэг думтаг байдал

вэ? Ингэснээр нөхөрлөлийн гишүүд болон орон нутгийн иргэдэд ямар ашиг тус болон ач холбогдолтой вэ?

Тухайн газар нутгийн байгалийн нөөцийн талаар:

- ◆ Хариуцан авч буй нутаг дэвсгэрт ямар төрлийн байгалийн баялаг, нөөц байна вэ?
- ◆ Ямар төрлийн ан амьтан, ургамал ямар

хэмжээгээр оршдог вэ? Ховордох аюул заналхийлсэн, ховордсон эсвэл устах аюул нүүрлээд буй ан амьтан, ургамал байна уу? Эдгээрээс улаан номонд бичигдсэн ан амьтан, ургамал байна уу? Эдгээр ургамал ан амьтдыг хамгаалахаар хэрэгжүүлж буй эсвэл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ болон төсөл байгаа эсэх? Хэрэв тийм бол, хэн санаачилж байгаа болон ямар арга хэмжээ авах вэ?

- ◆ Ямар төрлийн, хэр олон амьтан (шувуу гэх мэт) нүүдэллэдэг, өвөлждөг вэ?
- ◆ Экосистем нь жилд хэдий хэмжээний байгалийн нөөц баялаг бий болгодог вэ? Бэлчээрийн даац ямар байна вэ? Ямар хэмжээний ургац хураах боломжтой вэ? Нэгэн зэрэг адил нөөц баялаг тариалж ургац хураах эсвэл ургац хураахаар төлөвлөж буй өөр этгээд бий юу? Бусад этгээдүүд ингэхээр төлөвлөж байгаа бол нөөц баялагийг хэтрүүлэн ашиглахгүй байх талаар нөхөрлөл ямар арга хэмжээ авах вэ?
- ◆ Газар нутгийн хэдэн хувийг ой мод эзэлж байна вэ? Ой модтой бол газар нутгийн хэдэн хувийг нөхөрлөлд хариуцуулсан бэ? Эдгээр ой модыг хэрхэн ашиглаж байна вэ? Ой модтой газар нутгийн нөхцөл байдал ямар байна вэ? Ой мод байгалийнхаа жамаар нөхөн сэргээгдэж байна уу эсвэл багасч байна уу? Ой мод гал түймэр болон ойн хортон шавьжинд өртсөн эсэх? Хэрэв тийм бол, хэзээ ямар хэмжээний хохирол учирсан бэ?

- ◆ Тухайн газар нутаг усны нөөц баялагтай эсэх? Гол, горхи, нуур, рашаан болон халуун рашаан байна уу? Эдгээрийн нөхцөл байдал ямар байна вэ? Ус нь бохирдсон уу? Рашаан булгийн нөхцөл байдал ямар байна вэ?
- ◆ Орон нутгийн иргэдийн шүтэж тахидаг газар байна уу?



- ◆ Энэ газар нутагт тусгай хэрэгцээний газар байна уу? (Тусгай хэрэгцээний газрын тухай Хайрцаг 4-өөс харна уу).

Тухайн газар нутгийн нийгмийн асуудлууд:

- ◆ Малчдын өвөлжөө, хаваржаа болон гүний худаг байна уу? Байвал хаана, хэд байна вэ?
- ◆ Байгалийн гамшиг тохиолдох эрсдэл өндөр эсэх? Сүүлийн жилүүдэд тохиолдож байсан ба ирээдүйд учирч болзошгүй байгалийн гамшиг (жнь: зуны улиралд ган гачиг, өвлийн улиралд зуд)? Ийм гамшиг тохиолдох эрсдэл байгаа бол орон нутгийн иргэд ямар бэлтгэл арга хэмжээ авдаг вэ?
- ◆ Хариуцан авсан газарт ямар нэгэн бизнесийн байгууллага үйл ажиллагаа явуулдаг уу? Энэ нь нөхөрлөлийн гишүүдэд ямар хувилбар эсвэл боломжийг бий болгож байна вэ?
- ◆ Тухайн нутгийн байгалийн нөөцийн төрөл, хэмжээнээс шалтгаалан ямар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх

боломж байна вэ? (Уурхай, жуучлал, үйлдвэрлэл гэх мэт)

- ◆ Энэ нутгийн иргэдэд нийгмийн өөр ямар хүндрэлтэй асуудлууд байна? Байвал тэдгээр хүндрэлүүдийг үүсгэж байгаа ямар хүчин зүйлүүд байна вэ? Орон нутаг дахь уурхай болон бусад бизнесийн үйл ажиллагаанаас учирч байгаа болон учирч болох ямар сөрөг үр дагаврууд байна вэ?

- ◆ Нөхөрлөл нь хүний үйл ажиллагаанаас үүсэж байгаа сөрөг үр дагаварыг багасгах ямар арга хэмжээ хэрэгжүүлж болох вэ?
- ◆ Дундын санг арвижуулах ямар арга замууд байна вэ?
- ◆ Эдгээр асуудлуудыг нөхөрлөлийн хурлаар байнга хэлцэж байвал зохих ба сум болон аймгийн Засаг даргын Тамгын газар болон бусад байгууллагуудын зохион байгуулах сургалтын сэдвүүд болж болно.

Тухайн газар нутгийн байгаль орчныг хамгаалах талаар:

- ◆ Одоо учирч буй болон цаашид учирч болох байгаль орчны ямар хүндрэлтэй асуудлууд байна вэ? Эдгээр асуудлуудад ямар хүчин зүйлүүд нөлөөлж байна вэ? Учирч байгаа, учирч болзошгүй байгалийн болон нийгмийн хүндрэлүүдийн жишээг Хүснэгт 1-т үзүүлэв.
- ◆ Амьтан, ургамал, бусад байгалийн нөөцөд үзүүлж буй байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой ямар сөрөг нөлөө байна вэ? Эдгээрийг бууруулах ямар арга хэмжээ авч болох вэ?
- ◆ Байгаль орчны сөрөг нөлөө үүсгэж байгаа ямар хүчин зүйлүүд байна вэ? Сөрөг нөлөөг тодорхойлж жагсаалт гаргах. (ойн түймэр, бэлчээрийн даац хэтрүүлэх, уул уурхай, хулгайн ан, амьтан ургамлын өвчлөлт гэх мэт)
- ◆ Сөрөг нөлөөг бууруулахын тулд нөхөрлөл ямар үйл ажиллагаа явуулж болох вэ?
- ◆ Нөхөрлөлийн гишүүдийн суралцах явцыг тэмдэглэж баримтжуулах нь ирээдүйн ажилд хэрэгтэй болдог. Сургалтаар үзсэн сэдвүүд нь ирээдүйд дахин давтагдаж бөгөөд тэр цагт өнөөгийн үзсэн асуудлуудтай харьцуулаат хийж дүгнэлт гаргахад ашигтай болно.

Байгалийн Нөөцийн Менежментийн Төлөвлөгөө боловсруулахад анхаарах зүйлс

Нөхөрлөлийн гишүүд өөрсдийн амьдралын байдлыг ярилцаж ирээдүйд ямар болгох талаар төсөөлөлтэй болох нь ашигтай байдаг. Жишээлбэл, 5 жилийн дараа нөхөрлөлийн гишүүдийн амьдрал болон тэдгээрийн хариуцсан газар ямар байдалтай байхыг төсөөлөн, тодорхойлсон зорилтуудаа хүрсэний дараагаар газар нутаг ямар болох талаар зураглал боловсруулж болно. Зураглал нь а) одоогийн байгаль орчны болон нийгмийн үзүүлэлтүүдийг харуулсан, тухайн газар нутгийн байгалийн нөөцийг одоо хэрхэн ашиглаж байгааг үзүүлсэн (Зураг 1, 2-ыг харна уу), б) таван жилийн дараа байгаль орчны болон нийгмийн байдал ямар байдалтай болохыг харуулсан гэх мэт

Байгаль орчныг хамгаалах дундын сангийн талаар:

- ◆ Байгаль орчныг хамгаалах дундын сан гэж юу вэ? Түүний ашиглалтанд тавигдах шаардлага?
- ◆ Нөхөрлөл байгаль орчныг хамгаалах дундын санг хэрхэн байгуулах, хөрөнгө мөнгө босгох мөн захиран зарцуулах вэ? Хаанаас тусламж авч болох вэ?

Экосистем гэж юу вэ?

Тухайн нутгийн цаг агаарын нөхцөлд, янз бүрийн гадаргын ус болон газрын хэвлийн тогтоцтой тодорхой хэсэг газар нутагт дасан зохицон амьдарч байгаа амьтан, ургамлын холбоо бүхий цогц бүрэлдэхүүнийг экосистем гэж ойлгож болно. Экосистемийг бүрдүүлж буй бүх зүйлс цаг хугацаа өнгөрөх явцад хоорондоо оршин тогтнох тэнцвэрээ олдог. Үүнийг экологийн тэнцвэр гэнэ.

олон төрлийн байж болно. Ийм төрлийн дасгалаар нөхөрлөлийн гишүүд юуны төлөө хамтран ажиллаж байгааг дүрсэлсэн дүр зургийг бий болгоно.

Ирээдүйн дүр зураг хоёр үндсэн хэсгээс бүрдэж болно.

1. Нөхөрлөлд нэгдсэнээр гишүүдийн амьдрал хэрхэн дээшилсэн бэ?

2. Тухайн хариуцан авсан газар нутгийн байгаль орчин хэрхэн хадгалагдан, хамгаалагдаж үлдсэн болон хэрхэн дээшилсэн бэ?

Дээрх хоёр асуултад эерэг хариулт өгөх чадвартай байхын тулд нөхөрлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байх хэрэгтэй. Үр ашигтай байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад хэд хэдэн анхаарах зүйлс байдаг. Сайн төлөвлөгөөг боловсруулахад дараахь үндсэн зарчмуудыг баримтлах хэрэгтэй. Үүнд:

- ◆ Хэмжигдэхүйц үйл ажиллагааг төлөвлөх. Төлөвлөсөн ажлын үр дүнтөөн үзүүлэлтээр эсвэл өөр ямар нэгэн байдлаар хэмжигдэж байвал нөхөрлөлийн гишүүд ажлаа дүгнэхэд хялбар болно. Ингэснээр нөхөрлөлийн гишүүд амжилт болон анхаарал хандуулах шаардлагатай асуудлуудаа тодорхойлох юм.
- ◆ Санал зөвлөгөө авч байхыг төлөвлөгөөнд тусгах. Олон эх үүсвэрээс үнэн зөв мэдээлэл авах нь нөхөрлөлийн гишүүдэд өөрсдийн менежментийн үйл ажиллагааны нийгэм, байгаль орчин болон эдийн засгийн нөлөөллүүдийг үнэлж тогтооход туслах бөгөөд мөн байгууллагын гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргахад хэрэгтэй юм.
- ◆ Тодорхой цаг хугацаа, хариуцах эзнийг тавьж өгөх. Хэн, хэзээ, юу хийхийг тодорхой зааж өгвөл төлөвлөгөөний хэрэгжилт илүү амжилттай болно.
- ◆ Хэрэгжихүйц үйл ажиллагааг төлөвлөх. Нөхөрлөлийн гишүүдийн хүчин чадлын хүрээнд үйл ажиллагааг төлөвлөх, эс тэгвэл хэт өндөр төлөвлөсөн ажил хэрэгжихгүй цаг гарздах болно.

Дээрх төлөвлөлтийн зарчмуудыг хэрэгжүүлснээр нөхөрлөл нь ирээдүйн тодорхой чиглэл гаргаж, өөрийн ирээдүйн үйл ажиллагааг илүү үр ашигтай удирдахад суралцана.

3

НӨХӨРЛӨЛИЙГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ



Иргэдийн нөхөрлөлийг амжилттай хөгжүүлэхэд олон талын хамтын ажиллагаа шаардагддаг. Жирийн ард иргэдийн санал хүсэлт болон төрийн албан хаагчдын хууль зүйн үүрэг хариуцлагыг тусгалгүйгээр төлөвлөсөн арга хэмжээ нь амьдралд хэрэгжихдээ үр дүнгүй, үргүй зардал их гаргадаг сул талтай. Төрийн байгууллага жирийн иргэд аль алины оролцоотойгоор нөхөрлөлийн үйл ажиллагаа амжилттай явагддаг. Иймд гол оролцогчид хамтран ажилласны үр дүнд шийдвэр гаргах **хамтын ажиллагаа** нь амжилттай нөхөрлөлийн суурь үндэс болж өгнө.

Хамтран шийдвэр гаргаж, ялгаа зөрөлдөөнийг зөв зохицуулж, менежментийн төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх чадвартай байх нь хамгийн чухал юм. Үр дүнтэй хамтран ажиллаж чадахгүй байх нь ажлын урам зориг мөхөх болон бусад сөрөг үр дүнд хүргэдэг бол хамтын ажиллагаагаар асуудлыг шийдвэрлэснээр гишүүд тохиролцоонд хүрч илүү үр ашигтай ажилладаг байна. Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг хамтын ажиллагааны зарчмаар хэрэгжүүлэхийн тулд иргэдийн эрх ба төрийн байгууллагын хариуцлагыг харицан хүндэтгэж аливаа шийдвэрийг дээрх хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр боловсруулж гаргах учиртай.

Хамтын ажиллагаа нь доор дурдсан гурван үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- ◆ Хамтын менежмент
- ◆ Хамтын төлөвлөлт
- ◆ Иргэдийн оролцоотой үнэлгээ

Дээр дурдсан менежментийн хэлбэрүүд нь талуудын оролцоог нэмэгдүүлж,

тэдгээрийн оруулсан хувь нэмэрийг үнэлж, нөхөрлөлийг хөгжүүлэх өргөн хүрээтэй санаачлагуудыг дэмжих болно.

Хамтын менежмент

Нөхөрлөлийн гишүүд нь нөхөрлөлийн зохион байгуулалт, дундын сангийн зарцуулалт, тухайн байгалийн нөөц баялагийг ашиглах зэрэг нөхөрлөлийн бүхий л үйл ажиллагаанд санал өгөх, хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад оролцох эрхээр хангагдсан байна. (Нөхөрлөлийн журам 4.1) Иргэд, удирдлага, бусад оролцогч талууд эрх үүргийнхээ зааг ялгааг ухамсарлаж шийдвэр гаргах болон тэгш оролцоог хангаж, харилцан зөвшилцсөний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулахыг **хамтын менежмент** гэнэ. Энэ нь нөхөрлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа “дээрээс доошоо” удирдах чиглэлээр биш “доороос дээшээ” удирдан зохион байгуулах чиглэлийг баримтална гэсэн үг. “Доороос дээшээ” удирдах зарчмыг хэрэгжүүлэхэд нөхөрлөлийн тэргүүн, удирдлага, засаг дарга, ИТХ-ын тэргүүлэгчид нь хуучин захиргаадалтын удирдах арга барилыг үгүйсгэж нутгийн иргэдэд итгэл хүлээлгэж, тэдний санал сэтгэгдлийг анхааралтай сонсож үйл ажиллагаандаа тусгах нь чухал байдаг. Нөгөө талаас иргэд өөрсдөө хууль, дүрмээ чанд сахиж өөрсдийн эрх, үүргээ бүрэн ойлгосны үндсэн дээр нөхөрлөлийн үйл ажиллагаа, шийдвэрт идэвхитэй оролцдог байх нь чухал. Түүнчлэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад төрийн албан хаагчдыг үүрэг хариуцлагаа биелүүлэх хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэх нь өндөр ач холбогдолтой юм.

Хамтын менежментийн үндсэн ач холбогдууд:

- ◆ Хүчтэй хамт олныг бүрдүүлэх суурь болно.
- ◆ Хөдөө орон нутагт санал, мэдээллийг солилцох боломжийг нэмэгдүүлж, харилцан суралцах нөхцлийг бүрдүүлнэ.
- ◆ Нөхөрлөлийн үйл ажиллагаа болон шийдвэрүүд нь бүх гишүүд, оролцогч талуудад ил тод байдаг учраас амжилт, хариуцлагын эзэд тодорхой болдог.
- ◆ Амин хувиа хичээсэн үзлийг арилгаж “Вин-Вин” хандлагыг бүрдүүлнэ.

“Вин-Вин” хандлага

Энэхүү хандлага нь иргэдийн нөхөрлөлд амжилттай хамтын менежментийг хангахад маш чухал үүрэг гүйцэтгэнэ. “Вин-Вин” хандлага нь оролцогч тал бүрт ашиг тустай шийдэлд хүрэх асуудал дээр төвлөрдөг. “Вин-Вин” нөхцлийг бүрдүүлэхэд хамгийн гол анхаарах зүйл бол үйл ажиллагаанд оролцож буй бүх талууд, ялангуяа гишүүд урдаа тавьсан зорилгоо анхаарлынхаа төвд байлгаж, нэг нь нөгөөгөө өөлөх, хэрэгцээгүй шүүмжлэх, атаархах үзлийг халж, аль болох нэгнийхээ хийж байгаа ажлыг дэмжих, хүндрэлүүдийг ойлгох, туслах хандлагыг баримтлах нь чухал байдаг. “Вин-Вин” нөхцлийг Монгол хэл дээр “Хамтдаа ялах” гэж орчуулж болох ба энэхүү менежментийн хандлагын давуу талуудын талаар дэлгэрэнгүй тайлбарыг дор үзүүлэв.

Вин-Вин: Хамтран зүтгэгч байх уу, өрсөлдөгч байх уу?

“Вин-Вин” зарчим нь өрсөлдөн эсэргүүцэх харилцааны арга хэлбэрийг хамтын ажиллагааны арга хэлбэрт шилжүүлдэг хүчирхэг, хувь хүний харилцааны соёлын бүрэлдэхүүн юм.

Бид ихэнх тохиолдолд маргалдаанд хэрхэн оролцож байгаага хажуугаас харж өөртөө шүүмжлэлтэй хандаж чаддаггүй. Бас сэтгэлийнхээ хөөрлөөр шийдвэр гаргах, маргалдаанд оролцох гэх мэт олон жилийн турш зуршил болсон зангаа орхиход амаргүй байдаг. Шүүмжлэл маргалдааны эцэст ихэнх тохиолдолд бид “хөндий байдал”, “эсвэл би, үгүй бол чи” гэсэн хуваагдмал, сэтгэл дэнслүүлсэн бодолд ордог оос бус зөрчилдөөнийг “Хэн хэнийх нь хувьд нааштайгаар шийдвэрлэх өөр арга хэлбэр байна уу?” гэсэн асуудлыг бид өөрсдөдөө тавьж чаддаггүй.

Хүмүүс хоорондоо маргалдахдаа “Үгүй, үүнийг минийхээр хий”, “Үгүй, энэ чинь буруу байна” гэх мэтээр өөрийнхөөрөө зүтгэдэг байдал нь тухайн маргалдаанд зөрчлийг ажил хэргийн нэг хэсэг болгохоосоо илүү “Хүчээ үзсэн зөрчилдөөн” болгодог. Тэгвэл “Вин-Вин” хандлага нь:

Би ялахыг хүсч байна. Би ажил хэрэгтэй амжилттай байхыг хүсч байна.

Би бас таныг ялаасай гэж хүсч байна. Би бас Таныг ажил хэрэгтэй амжилттай байхыг хүсч байна.

гэсэн зарчим дээр хэрэгждэг.

Өөрсдийн хэрэгцээг хэрхэн “Вин-Вин” нөхцлөөр хангах вэ?

Хүмүүс, хамгийн түрүүнд учирч байгаа хүндрэлүүдийг хурдан шийдэх гэж яарахын өмнө эхлээд хамтран хэлэлцэж одоо тохиолдож байгаа хүндрэлтэй асуудлууд болон хэнд ямар хэрэгцээ байгаа талаар хоорондоо саналаа

Газрын тухай хууль

16-р зүйлийн 1.1-1.9: Монгол улсын тусгай хэрэгцээний газар гэдэгт дараахь газрууд хамаарна:

- ◆ Улсын тусгай хамгаалалттай газар
- ◆ Улсын хилийн зурвас газар
- ◆ Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар
- ◆ Гадаад улсын дипломат төлөөлөлөгчийн газар, мөн олон улсын байгууллагуудын суурин төлөөлөгчдийн газар
- ◆ Шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт, байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай
- ◆ Аймаг дундын отрын бэлчээр
- ◆ Улсын тэжээлийн сангийн бэлчээр
- ◆ Улсын тэжээлийн сангийн хадлангийн талбай
- ◆ Газрын тосны гэрээт талбай
- ◆ Чөлөөт бүсийн газар
- ◆ Аймаг, нийслэл, сум Газрын хуулийн дагуу өөрийн эрх хэмжээнд нийцүүлэн орон нутгийн газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан газар
- ◆ Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас тусгай хэрэгцээнд авсан газар.

дэлгэрэнгүй солилцох хэрэгтэй. Хоорондоо өөрсдийнхөө хэрэгцээний талаар нээлттэй ярилцах нь нэгнийгээ ойлгох, хэнд юу чухал байна гэдгийг тодруулж ойлгож авахад тусалдаг.



Дээрхээс үндэслэн “Хэн нь ямар сонирхолтой байна вэ?”, “Хэнд юу хамгийн чухал байна вэ?”, “Хэн ажлын ямар үр дүнг хүсч байна вэ?” гэсэн асуултаар хариу өгч чадна. Нээлтэй ярилцлага нь нөхөрлөлийн гишүүн бүрт хэрэгцээгээ бусдад ойлгуулах боломжийг олгоно. Түүнчлэн энэ нь үр дүнтэй хамтын ажиллагааны дараах суурь нөхцлийг бүрдүүлж өгнө:

Өөртөө болон бусдад шударга хандахыг би хүсч байна.

“Вин-Вин” хандлага доорх хэдэн зарчим дээр тулгуурлана. Үүнд:

- ◆ Хүмүүсийн ойрын болон урт хугацааны хэрэгцээ, сонирхолыг авч үзнэ.
- ◆ Хүн бүр өөр гэдгийг ухамсарлана.
- ◆ Хүмүүстэй мэдээлэл солицохдоо нөгөө хүнийхээ санаа бодол, итгэл найдвар, хүсэл зорилгыг анхааралтай

сонсож, хүмүүс яг юу хүсэж буйг ойлгохыг хичээх.

- ◆ Хувь хүмүүст хүндэтгэлтэй ханд. Хувь хүн рүү хэзээ ч дайрч болохгүй ба харин асуудал дээр анхаарлаа төвлөрүүл.

“Вин-Вин” хандлага нь шашны үзэл суртал, улс төрийн баримтлал, угсаа гарлаас хамааралгүй олон оронд амжилттай хэрэгжсэн нь туршлагаар батлагдсан билээ. Хүмүүсийн хоорондох итгэлцэл сул байсан ч энэхүү арга хэлбэр амжилттай хэрэгжиж хүмүүсийг амжилтанд хүргэж чаддаг байна. Иргэдийн нөхөрлөлд энэхүү хандлагыг амжилттай хэрэгжүүлж чадсан тохиолдолд иргэн бүрт ашиг тустай байх юм.

Хамтын төлөвлөлт

Хамтын менежментийн хоёрдахь иж бүрдэл нь хамтын төлөвлөлт юм.

Төлөвлөгөөг нэг эсвэл цөөн тооны хүн боловсруулж болох боловч энэ тохиолдолд төлөвлөгөөнд бусад талуудын хязгаарлагдмал тооны санал бодлыг тусгасан байдаг. Хамтын төлөвлөлтийн үед хамтын менежментийн нэгэн адил нөхөрлөлийн тэргүүн нөхөрлөлийн бүх гишүүд болон нөхөрлөлийн гишүүн бус хүмүүсийн санал бодол дээр тулгуурлан нөхөрлөлийн ирээдүйн чиглэлийг тодорхойлно. Байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны асуудлууд, тэдгээрийг цаашид хэрхэн арилгах, байгалийн нөөц баялагийг амжилттай нүдлэн хамгаалж түүнээс хүртэх боломжийг хэрхэн нэмэгдүүлэх талаархи ярилцлаганд олон талын оролцогчдыг хамруулах нь олон нийтийн дунд дэмжлэг бий болгоход туслана. Ярилцсан бүх асуудлыг ил тод байлгаж, төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, олон гишүүдийн оролцоог хангахын тулд уулзалтуудыг олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулж, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийг урих нь чухал юм.

Хамтын төлөвлөлт гишүүдийн ажлын идэвхийг дээшлүүлж амжилт гаргах болон хүндрэлтэй асуудлуудыг даван туулахад нөхөрлөлийн гишүүд нэг цөм болж ажиллахад тус нэмэр болдог. Хамтын төлөвлөлт нь хэдхэн хүний сэтгэлийн хөөрлөөр ажил төлөвлөхөөс урьдчилан сэргийлж, ойрын ирээдүйд тулгамдсан, нэн шаардлагатай ажлуудыг тогтоож, бодит хэрэгжихүйц ажлуудыг тодорхойлоход тусалдаг.

Иргэдийн оролцоотой үнэлгээ

Хамтын менежментийн гуравдахь иж бүрдэл нь иргэдийн оролцоотой үнэлгээ (ИОУ) юм. Хамтын менежментийн

Иргэдийн оролцоотой үнэлгээ яагаад чухал вэ?

Хийсэн ажил, учирч байгаа хүндрэлүүд, түүний шалтгаануудыг иргэдийн оролцоотой үнэлгээгээр тодорхойлж ажлаа сайжруулахад цаашид юу хийх талаар зөвлөмж гаргана. ИОУ нь:

- ◆ Одоо оршиж байгаа хүндрэлтэй асуудлууд ба нэн тэргүүнд тавигдах асуудлуудыг тодорхойлоход тусална.
- ◆ Байгалийн нөөцийг удирдан зохион байгуулах болон иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэх ажлуудыг эрэмбэлэхэд тусална.
- ◆ Иргэдээс суурь мэдээлэл цуглуулж боломжит шийдэл гаргахад тусална.
- ◆ Урт хугацааны зорилгоо биелүүлэхийн тулд хэрэгжихүйц зорилт дэвшүүлэхэд тусална.

бусад иж бүрдлийн адилаар ИОУ нь нөхөрлөлийн гишүүдийн ажил, тэдний ашиг сонирхол болон санал зөвлөмж дээр тулгуурладаг.

Аливаа иргэдийн нөхөрлөлийн үйл ажиллагаа нь тухайн орон нутагт өөрчлөлт авчирна. Иймээс байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс өмнө суурь үнэлгээ хийх нь чухал. Суурь үнэлгээг хийхэд иргэн бүр мэдээллээр хангагдах боломжтой, мөн үнэлгээнд санал өгөх эрхтэй. Иргэдийн

өгсөн мэдээлэл нь нөхөрлөлийн тэргүүнд зөв төлөвлөлт, үнэлгээг хийж зоригоо тодорхойлоход тусалдаг.

Иргэдийн оролцоотой үнэлгээ яагаад чухал вэ?

Аливаа ажлыг төлөвлөх болон гүйцэтгэхэд одоо оршиж буй хүндэрэлтэй асуудлууд, амжилтанд хүрэхийн тулд хэрэгжүүлэх хэмжигдэхүйц үйл ажиллагаанууд болон эдгээрээс нэн тэргүүнд тавигдах үйл ажиллагаануудыг тодорхойлох шаардлагатай байдаг. Энэ бүгд нь үнэлгээний систем юм.

Энэхүү үнэлгээний системийг хэзээ байгуулж, хэний үзэл бодол давамгайлах вэ? Нөхөрлөлийн гишүүдийнх үү? Орон нутгийн захиргааных юу? Нөхөрлөлд элсээгүй иргэдийнх үү? Үнэлгээг хийхдээ аль болох олон хүний санаа бодлыг сонсож, үнэлгээний системдээ тусгах хэрэгтэй юм. Үнэлгээний системийг боловсруулахад орон нутгийн иргэдийн төлөөлөл олноор оролцсон бол тэд ирээдүйд бий болох өөрчлөлтөнд хяналт тавихад туслах илүү сонирхолтой байх болно.

Нэг жишээ авч үзье. Нөхөрлөл тодорхой хэсэг газраас эмийн ургамал цуглуулахаар шийджээ. Эмийн ургамал

түүх ажил эхлэхээс өмнө нөхөрлөлийн гишүүд орон нутгийн иргэдийг эмийн ургамлын тархацыг судлах ажилд туслахыг хүсэв. Нөхөрлөл гишүүдийн хэлээцүүлэг болон мэргэжлийн хүмүүсийн зөвлөгөөн дээр үндэслэн нөхөрлөл нь тухайн эмийн ургамлын нөөцийг алдагдуулахгүйгээр жилд 100 кг эмийн ургамал түүхээр шийдсэн байна. Дараагийн жилүүдэд нөхөрлөл нь суурь үнэлгээний мэдээлэл цуглуулахад тусалсан иргэдээс дахин мэдээлэл цуглуулж, энэхүү мэдээллийг эмийн ургамлын нөхцөл байдлыг үнэлэх болон ирэх жилүүдэд түүх ургамлын тоо хэмжээг төлөвлөхөд ашиглав. Нөхөрлөлийн гишүүн бус иргэдийн оролцоог хангаснаар нөхөрлөл нь орон нутгийн иргэдийн дунд дэмжлэгтэй болохын зэрэгцээ хэрэгцээтэй мэдээллээ цуглуулж чадсан байна. Байгалийн нөөц ашиглалтыг тогтмол ажиглаж, тууштай бүртгэл хөтлөж, орон нутгийн иргэдийн дэмжлэгтэй үйл ажиллагаа явуулах нь экологийн өөрчлөлт болон эдийн засгийн үйл ажиллагааг эхнээс нь хянаж, гишүүд хоорондоо ярилцах нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм.

4

МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ



Нөхөрлөлийн үйл ажиллагааны явцад олон төрлийн маргаан зөрчил үүсч болно. Жишээлбэл, нөхөрлөлийн дотоод маргаан, нөхөрлөл хоорондын, нөхөрлөл болон төрийн захиргааны байгууллагын хооронд, нөхөрлөл ба аж ахуйн нэгжийн хооронд гэх мэт маргаануудыг хуулийн болон хууль бус аргуудаар шийдэж болно. Нэгэнт нөхөрлөл өөрөө иргэний байгууллага учраас аливаа маргааныг шүүхийн аргаар гэхээсээ илүүтэйгээр зөрчлийг хамтын хэлэлцээр, гуравдагч зуучлагчийн тусламжтайгаар, сонголт хийх гэх мэт аргуудыг ашиглан шийдвэрлэхэд үр дүн нь маргаанд оролцогч бүх талуудад ашигтай бас зардал бага орно. Ихэнхи тохиолдолд маргааныг хэлэлцээрийн замаар шийдэх нь цаг хугацааны хувьд хэмнэлттэй байх бөгөөд илүү үр дүнтэй байдаг. Өөр ямар ч аргаар шийдэж болохооргүй зөрчлийг шүүхээр шийдвэрлүүлвэл зохино.

Маргаан шийдвэрлэх хэлэлцээрийн болон бусад арга

Аливаа маргаан, зөрчлийг харилцан хэлэлцээрийн үндсэн дээр шийдвэрлэхэд байр сууриа хатуу хамгаалсан буюу тал бүрийн өөрчлөгдөшгүй шаардлага дээр тулгуурласан эсвэл хэрэгцээ сонирхол дээр тулгуурласан буюу хоёр талаасаа аль алиныхаа сонирхлыг гүн ойлгож, бүтээлч шийдлийн хүчээр тохиролцоонд хүрэх хоёр арга байдаг.

Амжилттай хэлэлцээр нь доор дурдсан зарчмуудад үндэслэнэ:

- ◆ Хэлэлцээрийн нөхцлүүдийг (үйл явц) тодорхой гарга.
- ◆ Бие биеэ анхааралтай сонсож, зөв ойлгож, итгэлцэл бий болго.
- ◆ Гол асуудал болон оролцож байгаа талуудын сэтгэлийг зовоож байгаа зүйлүүдийг тодорхой болго.
- ◆ Маргаан үүсгэж буй асуудлууд дээр анхаарлаа бүрэн хандуу (Хүн рүү бус, асуудал руу ханд).
- ◆ Талуудын ашиг сонирхолд нийцсэн бүтээлч шийдлийг эрэлхийл.

Доорх арга замуудыг ашиглан талууд хоорондын ялгаагаа аригаж болно.

- ◆ Маргааныг асуудал гэсэн үүднээс биш бие биенээсээ сурах, хөгжих боломж гэсэн үүднээс хар.
- ◆ Эсрэг талынхаа хүсэл, ашиг сонирхлыг ойлгож мэд.
- ◆ Шаардлагатай мэдээллийг цуглуу.
- ◆ Бие биенийхээ үгийг анхааралтай сонс. Анхааралтай сонссоноор маргалдаж буй бусад талуудтай харилцах харилцаа тань сайжирна.
- ◆ Эсрэг талынхаа сөрөг хандлагыг өөрчлөхийн тулд “Би”, “Миний” гэсэн ойлголт дээр бус, нийтлэг ашиг сонирхол дээр анхаарлаа хандуу.
- ◆ Сэтгэлийн хөөрлөөр шийдвэр бүү гарга.
- ◆ Дайралт, гүтгэлийг өнгөрөөж сур.

Маргааныг гуравдагч этгээдийн оролцоотойгоор шийдвэрлэх

Заримдаа талууд гуравдагч этгээдийн тусламж, дэмжлэгтэйгээр үр ашигтай тохиролцоонд хүрч чаддаг. Гуравдагч

этгээд шийдвэр гаргах үйл явцыг чиглүүлж өгдөг ба доорх зүйлсийг хийж гүйцэтгэдэг. Үүнд:

- ◆ Маргалдагч бүх талуудад дэмжлэг үзүүлдэг ба бүгдэд ашигтай шийдлийг олж тогтоодог.
- ◆ Маргалдагч талуудыг хоорондоо зөвшилцөж, асуудлыг эе эвээр шийдвэрлэхийг уриалдаг.
- ◆ Маргалдагч талуудын санал бодол, хүсэлтийг сонсож, талууд бие биенийхээ хэрэгцээ, шаардлагыг зөв ойлгосон эсэхийг магадална.
- ◆ Дайралт, доромжлол, буруушаалт, сүрдүүлгийг зөөлрүүлж, хүмүүсийн анхаарлыг харилцан буулт хийх тал руу хандууна.

Хэлэлцээр нь ихэвчлэн доорх дарааллаар явагддаг. Үүнд:

- ◆ Хэлэлцэж, тохиролцоонд хүрэх үндсэн дүрэм журмыг талууд тохиролцох.
- ◆ Асуудлыг тодорхойлж, танилцуулах.
- ◆ Талуудын хэлэх үгийг сонсох.
- ◆ Асуудлын учир шалтгааныг судлах (Хүн рүү бус, асуудал руу хандах ёстойг бүү март.).
- ◆ Эндүү ташаа ойлголт байвал засч залруулах.
- ◆ Маргаан үүсгэж буй бүх асуудлыг авч хэлэлцсэн эсэхээ магадлах.
- ◆ Маргалдагч талууд бие биенийхээ ашиг сонирхлыг (эсвэл байр суурийг) ойлгохыг хичээх .
- ◆ Аль аль талынхаа ашиг сонирхолд нийцсэн үр дүнг бий болгох хувилбар шийдлүүдийг тодорхойлох .
- ◆ Маргалдагч талууд бие бие хүндэтгэсэн байр сууринаас асуудлыг шийдвэрлэхийг хичээх.
- ◆ Талуудын сэтгэлд бүрэн дүүрэн нийцсэн ямар шийдэл байж болохыг

- ◆ тодорхойлох.
- ◆ Эсрэг талаа ялан дийлэх гэж оролдохын оронд бие биенийхээ ашиг сонирхолд хэрхэн нийцүүлэх тал дээр анхаарлаа хандуулах .
- ◆ Бүх талуудад ашигтай байх шийдэл дээр талууд тохиролцох.
- ◆ Тохиролцоо нь маш тодорхой, дэлгэрэнгүй байх.
- ◆ Тохиролцоог баримтжуулах
- ◆ Дүгнэлт хийж маргааныг дуусгавар болгох.

Маргааныг хуулийн дагуу шийдвэрлэх

Байгаль орчны сайдын 114 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу талууд өөрсдөө шийдвэрлэж чадахгүй нөхөрлөлийн үйл ажиллагааны явцад үүссэн маргааныг дараахь журмаар шийдвэрлэнэ:


- ◆ Нөхөрлөлийн гишүүдийн хооронд үүссэн маргааныг нөхөрлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ. Нөхөрлөл дотроо шийдвэрлэх боломжгүй маргааныг төрийн байгууллагад шилжүүлнэ.
- ◆ Баг, хорооны засаг дарга нь нөхөрлөлийн эрхийг зогсоох асуудлыг хэлэлцэх тохиолдолд тухайн баг, хороодын ИНХ хийхээс 10–аас доошгүй хоногийн өмнө нийтэд зарлан мэдээлнэ.
- ◆ Хурлын явцад гарсан нөхөрлөлийн гишүүдийн саналыг хурлын тэмдэглэлд оруулан баг, хорооны хурлын саналтай хамт сум, дүүргийн ИТХ–д уламжилна.
- ◆ Нөхөрлөлийн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг сум, дүүргийн ИТХ–аар

хэлэлцэж гарсан дүгнэлтийг сум, дүүргийн засаг даргад уламжилна.

- ◆ Нөхөрлөл нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо дараагийн шатны засаг дарга, эсвэл шүүхэд гаргаж болно.
- ◆ Иргэн, аж ахуйн нэгж, нөхөрлөл ялагалгүй хууль зөрчиж байгаль орчинд хохирол учруулсан бол Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Эрүүгийн хууль, Иргэний хууль болон бусад байгалийн нөөцийн ашиглалттай холбоотой холбогдох хуулиудын заалтын дагуу зохих шийтгэлийг хүлээнэ. Хавсралт 4-өөс нөхөрлөлийн гишүүдийн байгаль орчинтой холбоотой эрх, үүргийн талаар харна уу.
- ◆ Нөхөрлөлдүүдийн хооронд гарсан маргааныг сум, дүүргийн засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлэнэ.

Иргэдийн нөхөрлөлийг удирдан зохион байгуулах нь байнгын суралцах үйл явц байдаг. Үйл ажиллагааны явцад маргаан үүсэх нь хэвийн үзэгдэл. Харин гишүүд үүссэн маргааныг хэрхэн шийдвэрлэх нь нөхөрлөлийн урт хугацааны амжилтанд нөлөөлөх юм. Энэхүү бүлэгт авч үзсэн зарчмуудыг ашигласнаар нөхөрлөлийн гишүүд хамтран ажиллах туршлага ур чадварт суралцаж, хариуцсан газар нутаг болон орон нутгийн иргэдийн урт хугацааны сайн сайхан байдлыг хангаж чадах болно.

Байгаль орчныг
хамгаалах хуульд
оруулсан нэмэлт
өөрчлөлт нь ард
иргэдэд эх нутгаа
хамгаалахаас гадна
хуулийн этгээд
буюу нөхөрлөл
байгуулах замаар
байгалийн баялагийг
хариуцлагатайгаар
ашиглах боломжийг
олгож байгаа юм.



5

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦИ



Аливаа нөхөрлөл нь амьтан агнах, ховор ургамал цуглуулах гэх мэт байгалийн баялагийг өргөнөөр ашиглах эрхээр хангагдсан байдаг. Зарим төрлийн ан амьтан, ховор ургамлууд нь олон улсын гэрээ, конвенцүүдээр хамгаалагдаж, хил дамжуулан худалдаа наймаа хийхийг хориглосон эсвэл хязгаарласан байдаг. Монгол улс нь одоогийн байдлаар арав гаруй байгаль орчны холбогдолтой олон улсын гэрээ, конвенцүүдэд нэгдэн орсон байна. Эдгээр олон улсын гэрээ, конвенцүүд нь Монгол улсын үндэсний хууль тогтоомжуудтай адил үйлчлэх билээ. Иргэд аливаа байгалийн нөөцийг ашиглах болон худалдах төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн өмнө эдгээр олон улсын гэрээ, конвенцүүдийн талаар мэдлэгтэй байх нь чухал юм. Дэлхийн улс орнууд нь биологийн төрөл зүйл, байгалийн үзэсгэлэнт газар, нутгийн иргэдийн тахин шүтдэг газрууд болон орон нутгийн иргэдийн байгаль орчны мэдлэг, ардын соёл, уламжлалыг хүн төрлөхтөний өв баялагийг хамгаалахын үнэ цэнийг хүлээн зөвшөөрч доорх гэрээ конвенцуудад нэгдсэн байдаг байна. Хүснэгт 2-нд Монгол улсын нэгдэн орсон байгаль орчны тоомхон гэрээ, конвенцүүдийн ач холбогдлыг тайлбарласан болно.

Хүснэгт 2. Монгол улсын нэгдэн орсон байгаль орчны конвенцүүдийн тухай

Нэгдсэн он	Монгол улсын нэгдэн орсон байгаль орчны конвенцүүд	Конвенцийн зорилго ба агуулга
1993	<p>Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай Энэ конвенци эгнээндээ дэлхийн 190 орчим улсыг нэгтгэсэн хамгийн анхны дэлхий дахины гэрээ бичиг юм</p>	<ul style="list-style-type: none"> • Биологийн төрөл зүйлийг хамгаалах • Биологийн төрөл зүйлийг тогтвортой, урт удаан хугацаанд ашиглах • Түүнээс гарах үр ашгийг тэнцүү хуваах гэсэн гурван зорилготой • Биологийн төрөл зүйлийг хамгаалах болон урт хугацаанд тогтвортой ашиглах үндэсний стратегиуд боловсруулах зорилготой. Энэхүү конвенцийг тогтвортой хөгжлийн асуудлыг хөндөсөн гол баримт гэж үздэг
1993	<p>Цаг уурын өөрчлөлтийн тухай нҮБ-ын конвенци Энэ конвенцэд 190 орчим улс нэгдэн орсон</p>	<ul style="list-style-type: none"> • Дэлхий дулааралтай тэмцэж, ирээдүйд бий болох дулааны хэмийн өсөлтийг шийдвэрлэхийн тулд агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламжийг бууруулахад чиглэсэн
1996	<p>Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлсийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци Энэ конвенцэд 172 улс нэгдэн орсон</p>	<ul style="list-style-type: none"> • Зэрлэг амьтан, ургамлын аймаг нь олон төрөл зүйл, үзэсгэлэнт сайхан болоод янз бүрийн хэлбэр төрхөөрөө энэ ертөнцийн байгалийн тогтолцооны орлуулалтгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийг хамгаалж өнөөгийн болоод хойч үеийнхэндээ өвүүлэн үлдээх ёстойг оролцогч талууд хүлээн зөвшөөрч устгах аюулд орсон зүйлүүдийг төлөөлөх биетүүдийг худалдаалахыг зөвхөн онцгой нөхцөлд зөвшөөрөх ба тэдний оршин тогтнох байдалд аюул занал учруулахгүйгээр хатуу хяналт, зохицуулалтын доор явуула. Энэхүү конвенцээр 33,000 гаруй төрөл зүйлийг янз бүрийн түвшний хамгаалалтанд авсан
1996	<p>Ган, цөлжилтэй тэмцэх нҮБ-ын конвенци Энэ конвенцэд дэлхийн 192 гаруй улс нэгдэн орсон</p>	<ul style="list-style-type: none"> • Ган, цөлжилт нь дэлхийг хамарсан асуудал болж, дэлхийн даяр 250 сая гаруй хүн нэрвэгдэж буйг хүлээн зөвшөөрч ган, цөлжилтэй тэмцэх, тэдгээрийн нөлөөллийг бууруулах шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн гэрээ; усны эх үүсвэрийг хамгаалж, хадгалах урт хугацааны стратегиуд бүхий үндэсний арга хэмжээний хөтөлбөрүүдийг сурталчилж дэмждэг

Нэгдсэн он	Монгол улсын нэгдэн орсон байгаль орчны конвенцүүд	Конвенцийн зорилго ба агуулга
1997	<p>Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай базелийн конвенци Энэ конвенцэд ойролцоогоор 170 улс нэгдэн орсон байна</p>	<ul style="list-style-type: none"> • -Үйлдвэрлэлийн өсөлттэй уялдан гарах аюултай болон бусад хог хаягдлын төвөгтэй шинж байдал, тэдгээрийг хил дамжуулан тээвэрлэх явцад хүний эрүүл мэнд, байгаль орчинд учрах аюул улам нэмэгдэж байгааг ухамсарлан; улс орнууд аюултай болон бусад хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх болон түүнийг зайлуулах зэрэг менежментийн асуудлууд нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд хор хөнөөлгүйг баталгаажуулах арга хэмжээг авах хэрэгтэйг хүлээн зөвшөөрсөн
1997	<p>Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, усны шувуудын олноор амьдрах орчны тухай рамсарын конвенц Энэ конвенцэд ойролцоогоор 157 гаруй улс нэгдэн орсон</p>	<ul style="list-style-type: none"> • Ус, намгархаг газар нь усны горим болон ургамал, амьтны аймаг, ялангуяа усны шувуудын амьдрах орчны экологийн зохицуулагч болдог үндсэн үүрэгтэйг харгалзан • Ус, намгархаг газар нь эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, чөлөөт амралтын дахин нөхөн сэргээхэд туйлын бэрхшээлтэй үнэт нөөц баялаг болохыг ухамсарлан • Усны шувууд улирлаар хил дамжин нүүдэллэдэг учир түүнийг олон улсын нөөц баялгийн нэгэн адил үзэх ёстойг хүлээн зөвшөөрөв

Дүгнэлт

Саяхан батлагдсан Байгаль Орчныг Хамгаалах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Монгол улсын иргэдэд аж ахуйн нэгж байгуулан, хуулийн дагуу бүртгүүлж уг аж ахуйн үйл ажиллагаагаараа тухайн нутгийн байгаль орчныг хамгаалж мөн хариуцан авсан газар нутгийнхаа байгалийн нөөцийг ухамсартайгаар ашиглах боломжийг бүрдүүлж өгсөн. Иргэдийн нөхөрлөл нь тодорхой хэмжээний газар нутгийг тодорхой хугацаанд эзэмших эрхээр хангагдсан байна.

Газар бүрт экосистем өөр байж, нөхцөл байдал иргэдийн нөхөрлөл бүрт мөн өөр өөр байх учраас энэхүү гарын авлага нь иргэдийн оролцоотой байгаль орчныг хамгаалах ерөнхий зарчим дээр тулгуурлан зохиогдсон болно. Гарын авлагад нөхөрлөлийн гишүүд болон бусад холбогдох талуудын эрх, үүрэг, тухайн орон нутгийн хөгжил болон байгалийн нөөцийг хамгаалах үйл явц дахь тэдгээрийн үүргийг авч үзсэн. Энэхүү гарын авлага нь өөртөө байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө хэрхэн боловсруулах, нөхөрлөлийг хэрхэн удирдан зохион байгуулах болон маргаан шийдвэрлэх аргуудын талаар зарим зөвлөмжүүдийг багтаасан болно. Түүнчлэн иргэд, малчдад санаа өгөх зорилгоор нөхөрлөлийн хөгжлийн янз бүрийн шатанд ашиглагдах дэлгэрэнгүй асуултуудыг гарын авлагад санал болгосон билээ. Эцэст нь гарын авлагаар, иргэд болон нөхөрлөлийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг шүүхийн аргаар маргааныг шийдвэрлэхийг цааргалж, аль болох тохиролцооны аргаар маргааныг шийдвэрлэхийг зөвлөмж болгож, бусад улс оронд өргөн хэрэглэдэг зарим аргуудын талаар тайлбарлав.

Гарын авлагад нөхөрлөлийн санхүүгийн менежмент хийх, дундын санг хөгжүүлэх, төрийн байгууллагатай хамтран ажиллах зарчмууд болон байгалийн нөөцийг ашиглах талаар Засгийн газрын журмууд (ой цэвэрлэх ба нөхөн сэргээх журам, ан амьтан агнах журам, ховор ургамал цуглуулах журам гэх мэт), мөн төлбөрийн талаар дэлгэрэнгүй бичигдээгүй болно. Эдгээр асуудлуудыг хамарсан иргэдэд зориулсан гарын авлага гаргах нь чухал бөгөөд ирээдүйд тийм гарын авлага боловсруулагдаж гарна гэж найдаж байна. Энэхүү гарын авлага нь Нөхөрлөл байгуулж байгалийн баялагийг хамгаалах ашиглах иргэдэд зориулсан гарын авлагын анхны хэвлэл юм. Иргэд энэхүү гарын авлагыг хэрэгжүүлэн ашиглаж, хэрхэн сайжруулах талаар саналаа бидэнд ирүүлснээр гарын авлага цаашид улам боловсронгуй болно гэдэгт Азийн сан найдаж байна.

Хавсралт 1. Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах иргэдийн нөхөрлөл байгуулахад бүрдүүлэх бичиг баримтууд

- ◆ Нөхөрлөлийн нэр, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, хаяг, байнга орших газрын хаяг, хариуцан хамгаалах байгалийн нөөц баялгийн талаарх тайлбар,
- ◆ Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр
- ◆ Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан, нөхөрлөл болон орон нутгийн иргэдийн гарын үсэг зуралцсан байглийн нөөцийн менежментийн төлөвлөгөө
- ◆ Нөхөрлөл байгуулсан гишүүдийн болон нөхөрлөлийн удирдлагын хамтран ажиллах тухай гэрээ
- ◆ Нөхөрлөлийн дүрмийн хуулбар
- ◆ Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулахыг хүссэн өргөдөл
- ◆ Нөхөрлөлийн гишүүдийн иргэний үнэмлэхийн хуулбарууд .

Хавсралт 2. Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээний загвар, Байгаль орчны сайдын 114 тоот тушаалын 2-р хавсралт

Байгаль орчны сайдын 2006 оны __ сарын __ өдрийн __ тоот 2-р хавсралт

Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах гэрээний загвар

БАТЛААВ:

Сум, дүүргийн Засаг дарга

Аймаг (хот) Засаг Даргын Тамгын Газрын Байгаль Орчны Хэлтсийн Дарга

Нөхөрлөлийн Тэргүүн

Нөхөрлөлийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулах Гэрээ №

200__ оны __ сарын __ өдөр

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Монгол Улсын Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1 дүгээр

зүйлийг үндэслэн нэг талаас _____

аймаг /нийслэл/- ийн _____ сум дүүргийн Засаг

даргын Тамгын газрыг төлөөлж _____

ажилтай _____ овогтой _____

/ гэрээнд цаашид ‘засаг дарга’ гэх /, нөгөө талаас _____

нөхөрлөлийг төлөөлж _____ ажилтай _____

овогтой _____ /гэрээнд цаашид “нөхөрлөл” гэх/ нар харилцан

тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2 _____ нөхөрлөл нь тус сум, дүүргийн _____

_____ хамрах _____ га газар дахь байгалийн тодорхой төрлийн баялагийг /

цаашид “гэрээт газар” гэх/ 200__ оны __ сарын __ –ны өдрөөс 200__

оны __ сарын __-ны өдрийг хүртэл хугацаанд Байгаль орчныг хамгаалах

тухай хуулийн 31.1 дүгээр зүйлд заасны дагуу хариуцан хамгаалах,

эзэмшихээр тохиролцов.

Хавсралт 3. Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөлийн гэрчилгээний загвар, Байгаль орчны сайдын 114 тоот тушаалын 3-р хавсралт

Байгаль орчныг хамгаалах иргэдийн нөхөрлөлийн гэрчилгээ

Дугаар _____

Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.8-д Байгаль Орчны Сайдын 2006 оны 114 тоот тушаалаар батлагдсан “Байгалийн тодорхой төрлийн баялагийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам” болон сум /дүүргийн/ засаг даргын 200__ оны __ тоот захирамжийг үндэслэн _____ аймаг /нийслэл/-ийн _____ сум/ дүүрэг/-ын _____ нэртэй газрын __ (га талбайн) байгаль орчны биологийн төрөл зүйлийг хамгаалах, _____ нөөцийг зохистой ашиглах зорилгоор. _____ сум, дүүрэг дэх _____, _____ нөхөрлөлд _____ жилийн хугацаатайгаар гэрээгээр эзэмшүүлэв.

Сунгалт

Гэрчилгээний хүчинтэй байх хугацааг 200__ оны __ сарын __ өдөр хүртэл сунгав.

Тамга

Гэрчилгээ олгосон:

_____ аймаг /нийслэл/ - ийн _____ сум /
дүүрэг/-ын засаг дарга _____ /

Тамга

200__ оны __ сар __ өдөр

Хавсралт 4. Нөхөрлөл болон сум, дүүрэг, баг, хорооны засаг даргын байгаль орчныг хамгаалах эрх, үүрэг

	Эрх	Үүрэг
Нөхөрлөл	<ul style="list-style-type: none"> Зөвшөөрөгдсөн улиралд, хуулийн хүрээнд ан хийх Барих агнуурын амьтны тоо, хэмжээний дээд хязгаар, зөвшөөрлийн дотор ан, агнуур хийхэд хууль тогтоомжийн дагуу хяналт тавих Агнуурын буруутай үйл ажиллагааг таслан зогсоох Гэрээгээр заасан газар, нутаг байгалийн нөөцийг хариуцан хамгаалах Байгалийн нөөцийн дагалт баялаг (самар, жимс, эмийн ургамал, амьтан ... гэх мэт) бусад тогтвортой үр өгөөжийг аймгийн БО-ны албанаас олгосон байгалийн нөөц баялаг эзэмших, ашиглах эрхийн бичгийн дагуу хүртэх, ашиглах 	<ul style="list-style-type: none"> Ой, ургамлын нөөц: Хариуцан хамгаалж буй ойн нөөцийг түймэр, өвчин, хортон шавьжаас хамгаалах ажлыг зохион байгуулах Түүний нөхөн сэргээлтийн үед мал оруулахгүй байх, хувиар гарган ашиглуулах Түймэр гарсан үед холбогдох албан тушаалтнуудад шуурхай мэдэгдэх, унтраах арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулах, зохих тусламжийг дарихуан авах (Хавсралт 5-ыг харна уу) Ой, ургамлын болон бусад байгалийн нөөцийг арвижуулах, цэвэршүүлэх, нөхөн сэргээх ажлыг өөрийн хөрөнгөөр болон төв орон нутгийн дэмжлэгээр мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу гүйцэтгэнэ. (Хавсралт 6, 7-г харна уу) Таримал ойг хугацаанд нь ойн санд шилжүүлэнэ Тухайн ойгоос бэлтгэх хэрэглээний болон түлээний мод, байгалийн дагалт баялагт холбогдох журам, зөвшөөрөгдсөн хэмжээ, гэрээний нөхцлийн дагуу хяналт тавих Хариуцсан нутаг дэвсгэр дээрх зорчигчид болон жуулчид холбогдох хууль тогтоомжийг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих
Сум, дүүргийн засаг дарга	<ul style="list-style-type: none"> Нөхөрлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг тооцох Нөхөрлөлийн хариуцаж байгаа байгалийн нөөцийн өөрчлөлтөнд жиад нэг удаа шалгалт, дүн шинжилгээ хийх 	<ul style="list-style-type: none"> Нөхөрлөлийн гишүүдийн саналыг зохих дээд шатны байгууллагад уламжлах, сургалт, зөвлөлгөө өгөх, нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Нөхөрлөлийн үйл ажиллагааг орон нутгийн иргэдэд таниулан сурталчлах Байгалийн нөөцийг удирдан зохион байгуулах төлөвлөгөөг ИТХ-тай хамтран хэрэгжүүлэх Нөхөрлөлийн дундын санд зохих хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх

	Эрх	Үүрэг
Баг, хорооны засаг дарга	<ul style="list-style-type: none"> • Байгалийн нөөцийг зохисгүй ашиглаж, орчныг доройтуулж, бохирдуулах зэргээр гэрээний үүргээ зөрчиж байгаа тохиолдолд нөхөрлөлийн буруутай үйл ажиллагааг зогсоох талаар сум, дүүргийн засаг даргад санал оруулах • Нөхөрлөлийн хамт олон бэлчээр сэлгэх, хуваарьтай ашиглах, сэргээн сайжруулах, байгалийн нөөцийг хамгаалах үйл ажиллагааны хувиарийг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн тогтоож мөрдүүлэх • Эдгээр шийдвэрийн хэрэгжилтийг баталгаажуулах 	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих, чиглүүлэх
Аймаг, нийслэлийн БО-ны албаны эрх, үүрэг (БО-ны Усын байцаагч, байгаль хамгаалагч)	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт тавьж, мэргэжлийн зүгээс санал, дүгнэлт хийх • Нөхөрлөлийн байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт, дүгнэлт хийх • Нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоох шаардлагатай гэж үзсэн саналыг үндэслэлтэйгээр сум, дүүргийн засаг даргад тавих • Нөхөрлөлийн байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн сумын байгалийн нөөц ашигlaatын хувиарт оруулж байгалийн нөөц эзэмших, ашиглах эрхийн бичгээр хангана 	<ul style="list-style-type: none"> • Мэргэжлийн зөвлөгөө болон сургалтаар хангаж, мэдээлэл солилцох • Нөхөрлөлийн хөгжилд хувь нэмэр оруулах сургалт зохион байгуулах, санхүүжүүлэх • Сум дүүргийн засаг дарга нарын зөвлөмж дээр үндэслэн нөхөрлөлд санхүүгийн болон шаардлагатай бусад дэмжлэг үзүүлэх

Хавсралт 5. Монгол улсын иргэний байгаль орчныг хамгаалах эрх, үүрэг болон хариуцлага

Монгол Улсын Үндсэн Хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> Монгол улсын иргэн Та эрүүд, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй \16.2\ 	<ul style="list-style-type: none"> ... байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн үүрэг мөн \17.2\

Байгаль орчныг хамгаалах тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> Гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөө үзүүлдсний улмаас эрүүд манда, эд хөрөнгөнд хохирол учирсан бол буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх Байгаль орчны хууль тогтоомжийг зөрчсөн болон байгаль орчинд хортой нөлөө учруулсан этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах эрхтэй Байгаль хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан бүрдүүлэх, нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялагийг арчаан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх Холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн зөв мэдээлэл авах Байгаль орчинд хортой аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөө үзүүлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах Сайн дурын үндсэн дээр нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялагийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших эрхтэй \4.1.1-6\ 	<ul style="list-style-type: none"> Байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил эзэмшиж хэрэглэх, үр хүүхэддээ экологийн хүмүүжил олгох Байгаль орчинд хортой нөлөөлөхөөс сэргийлэх, өөрийн буруугаас учруулсан хортой нөлөөлөл, түүний хохирлыг арилгах буюу нөхөн төлөх Байгалийн баялагийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй \4.2.2-4\

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль\ТХГНТХ\	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлэнэ: <ul style="list-style-type: none"> - Өөрийн нутаг дэвсгэр дэх тусгай хамгаалалттай газар нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар засаг даргын илтгэлийг хэлэлцэж зохих шийдвэр гаргах, түүний биелэлтийг хангуулах - Нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг улсын тусгай хамгаалалтанд авах тухай саналыг дээд шатны ИТХ буюу Засгийн газарт уламжлах, - Нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн хамгаалалтанд авах тухай шийдвэр гаргах, түүний хилийн зааг, хамгаалалтын горимыг тогтооно эрхтэй \28.1-28.3\ 	<ul style="list-style-type: none"> • Хууль тогтоомж зөрчигчдөө хүлээлгэх хариуцлага: <ul style="list-style-type: none"> - Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын горимыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж иргэнийг 20,000 хүртэл, аж ахуйн нэгж, байгууллагыг 100,000 хүртэл төгрөгөөр торгох - Байгалийн нөөцөт болон дурсгалт газар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж иргэнийг 2,000-20,000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50,000-100,000 төгрөгөөр торгох - Байгалийн цогцолбор газарт хууль бус үйл ажиллагаа явуулсан бол олсон орлогыг хурааж иргэнийг 1,000-20,000, аж ахуй нэгж, байгууллагыг 50,000-100,000 төгрөгөөр торгох - ТХГ-г судалгаа шинжилгээний ажил явуулахдаа газрын төлөв байдал, хөрс, ус, агаар, ус, амьтны аймагт сөргөөр нөлөөлж хохирол учруулсан бол иргэнийг 5,000-25,000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50,000-100,000 төгрөгөөр торгох - Дархан цаазат газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж иргэнийг 10,000-50,000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50,000-250,000 төгрөгөөр торгоно. \43.3.1-5\

Байгаль орчны үнэлгээний тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Тухайн нутгийн иргэд, сум, дүүргийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн саналыг байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй төслийн байгаль орчны үнэлгээний тайланд хуулийн дагуу тусгах шаардлагатай \5.4.8\ 	<ul style="list-style-type: none"> • Уул уурхай, жуучлал гэх мэт байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэнд тухайн орон нутгийн сум, дүүргийн ИТХ, түүний Тэргүүлэгчид хяналт тавина \6.4\

Газрын тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Баг, хороодын ИНХ нь <ul style="list-style-type: none"> - Газар ашиглалт, хамгаалаагын талаарх засаг даргын тайланг хэлэлцэх, дүгнэх эрхтэй; ИНХ нь газар ашиглалт болон хамгаалаагын үнэлж, зөвлөмж өгөх эрхтэй болно - Нийтийн эдэлбэр газрын ашиглалтыг зохион байгуулах эрхтэй 	<ul style="list-style-type: none"> • Баг, хороодын ИНХ нь баг, хорооны нутаг дэвсгэр дэх нийтийн эдэлбэр газрын эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах • Аймаг, сум, дүүргийн засаг дарга дараахь тохиолдолд газар эзэмших гэрчилгээг хүчингүй болгоно. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн - Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгааллын ашиг сонирхолд харшаар ашигласан нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр нотлогдсон тохиолдолд - Шилжүүлж авсан эрхийг уусын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй - Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй - Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй - Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын үйл ажиллагаа явуулаагүй зэрэг тохиолдлууд орно • Газар эзэмшигч, ашиглагч нь дараахь шаардлагыг биелүүлэнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, хөрс талхаагдах, элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах - Ойн төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах

Газрын төлбөрийн тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
—	<ul style="list-style-type: none"> • Гэрээ байгуулан газрыг эзэмшиж, ашиглаж байгаа Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага...газрын төлбөр төлөгч байна • Газар эзэмшүүлэх, ашигуулах гэрээний дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа газрын нэгдмэл сангийн \Хавсралт 6-гаас газрын нэгдмэл сангийн тухай үзнэ үү\ үндсэн ангилалд хамаарах болон тусгай хэрэгцээний газарт төлбөр ноогдуулна • Газрын төлбөрийн тухай хуульд нөхөрлөлд эзэмшүүлж буй газрын төлбөрийн талаар тодорхой заалт байхгүй

Усны тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Баг, хороодын ИНХ нь нутаг, дэвсгэртээ усны тухай хууль тогтоомжийг хэрхэн хэрэгжүүлж байгаа тухай баг, хорооны засаг даргын мэдээллийг сонсох • Багийн нутаг, дэвсгэрт байгаа худаг, усан сан, усалтын системийн ашиглалт, эзэмшлийг зохицуулах, бэлчээр, хадлан, тариаланг усжуулах зорилгоор худаг гаргах, далан, усан сан, усалтын систем байгуулах талаар засаг даргын саналыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй. • Гэрээ байгуулж, зөвшөөрөл авснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх баталгаажна. Ус ашиглах гэрээг 20 хүртэл жилээр байгуулж, шаардлага хангасан бол эрхийг 5 хүртэл жилээр сунгана • Ус ашиглахыг хүссэн этгээд сум, дүүргийн байгаль хамгаалагчтай ус ашиглах гэрээг байгуулна • Ус ашигуулах шийдвэрийг сум, дүүргийн засаг дарга гаргана • Өөрийн хүч хөрөнгөр цас, борооны ус хуримтлуулж, нуур цөөрөм байгуулсан, худаг гаргасан, хуучин усалтын систем, үст цэгийг засч, тохижуулан тоногосон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн байгууламжийг давуу эрхээр эдэлнэ 	<ul style="list-style-type: none"> • Ус ашиглах гэрээг дараахь тохиолдолд хугацаанаас нь өмнө цуцална. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Гэрээнд заасан үүргээ биедүүлээгүй - Байгаль хамгаалах болон Усны тухай хуулийг зөрчсөн - Ус ашигласны төлбөрөө хугацаанд нь төлөөгүй - Усны эх үүсвэрийг бохирдуулсан - Ус ашигласан тооцоог хуурамчаар тогтоосон - Усны сав газрын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн • Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж ус ашигласны төлбөр төлнө • Ус бохирдуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж ус бохирдуулсны нөхөн төлбөр төлнө

Рашааны тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Рашааныг ашиглах тухай иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтийг аймаг, сум, дүүргийн ИТХ-аар шийдвэрлэнэ • Рашаан ашигласны төлбөрийн хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх журмыг Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуулиар тогтооно 	<ul style="list-style-type: none"> • Тухайн рашааны орд газрын байгалийн баялагийг аймаг, сум, дүүргийн ИТХ, засаг даргын зөвшөөрөлгүйгээр ашиглахыг хориглоно • Тухайн рашааны орд газрын \орчмын бүсэд\ газрын хөрс, ургамалыг бохирдуулах, мал бэлчээрүүлэх, бүх төрлийн хог хаяхыг хориглоно • Рашааныг бохирдуулсан, бохирдлоос хамгаалах шаардлагыг биелүүлээгүй, ариун цэврийн дэглэмийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй тохиолдолд иргэн, албан тушаалтныг 25,000-30,000 төгрөг, хуулийн этгээдийг 250,000-300,000 төгрөгөөр тус тус торгоно

Ойн тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай баг, хорооны засаг даргын мэдээллийг сонсох • Нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлэх, гэрээг цуцлах саналыг засаг даргад уламжлах • Ойн тухай хууль тогтоомжийг зөрчсөний улмаас ойн санд, эсвэл хүний эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан бол хариуцлага хүлээлгэх, хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах • Холбогдох байгууллагаас ойн нөөц, түүний хамгаалалт, ашиглалтын талаар үнэн зөв мэдээлэл авах • Нөхөрлөл нь гэрээгээр эзэмшсэн газартаа Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу идэвхитэн байгаль хамгаалагчийг ажиллуулж болно (Нөхөрлөл нь энэ хуулийн 18.8-д заасан гэрээний хүрээнд дараахь эрхтэй): <ul style="list-style-type: none"> - Эзэмшлийн газартаа менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах - Эзэмшлийн газраасаа менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт нөөцийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт нөөцийг худалдан борлуулах - Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх ойн аж ахуйн арга хэмжээний төсөл, хөтөлбөр боловсруулах, санал өгөх, уралдаант шалгаруулалтад оролцох - Менежментийн талаар явуулах сургалт, семинар, мэргэжил олгох, давтан сургах үйл ажиллагаанд хамрагдах 	<ul style="list-style-type: none"> • Нөхөрлөл нь ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, ашиглах менежментийн төлөвлөгөөтэй байна • Нөхөрлөл нь сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялагийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавина • Нөхөрлөлийн гишүүдийн 80-аас доошгүй хувь нь гэрээгээр эзэмшиж байгаа ойн сангаа байнга харж хамгаалах, хяналт тавих боломжтой, тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн байнгын оршин суугч иргэд байна • Дараахь тохиолдолд тухайн сум, дүүргийн засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр явуулах нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах, эзэмших чиглэлээр явуулах үйл ажиллагааг зогсоох тухай баг, хорооны - Иргэдийн Нийтийн Хурлын санал, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарсан тохиолдолд - Энэ хуулийн 18.6, 18.8-д заасан нөхцөл, шаардлага болон гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсвэл гэрээ байгууснаас эхлэн 6 сарын хугацаанд ойг хамгаалах чиглэлийн үйл ажиллагаа явуулаагүй тохиолдолд

Химийн хорт, аюултай бодисын тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр худалдаа, хил, гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон холбогдох бусад байгууллага нь салбар чиг үүрэгтэй уялдсан химийн хорт болон аюултай бодисын мэдээллийн сангай байх бөгөөд энэ сангийн болон бодисын шинж чанар, осол эрсдэлийн үед авах арга хэмжээ, тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх аргын талаарх мэдээллийг иргэд үнэ төлбөргүй авах эрхтэй • Иргэд, төрийн бус байгууллага нь химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаарх санал хүсэлтээ холбогдох төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрмүүлэх эрхтэй 	<ul style="list-style-type: none"> • Химийн хорт бодисын талаарх журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, албан тушаалтан уг хуулийн дагуу болон Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээж торгуулиас авахуулаад хоригдох хүртэл шийтгэл хүлээнэ

Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлын тухай хууль	
Иргэн ба Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх	Үүрэг, хариуцлага
<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах эрхтэй 	<ul style="list-style-type: none"> • Үүсгэсэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлж байх

Хавсралт 6. Газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал. Газрын тухай хуульд

10.1 Монгол Улсын газрын нэгдмэл санг дараахь байдлаар ангилна:

- 10.1.1** Хөдөө аж ахуйн газар
- 10.1.2** Хот, тосгон, бусад суурин газар
- 10.1.3** ТЗам, шугам, сүлжээний газар
- 10.1.4** Ойн сан бүхий газар
- 10.1.5** Усны сан бүхий газар
- 10.1.6** Тусгай хэрэгцээний газар



CONSERVATION *ink*



The Asia Foundation



**Koninkrijk
der Nederlanden**

Монгол улс дахь Азийн Сангийн “Ирээдүйгээ Баталгаажуулах нь” Хөтөлбөрөөс бэлтгэв.
Нэгдсэн Үндэсний Гудамж, Ш/х 1003, Улаанбаатар хот-13; Утас: (976-11) 330-524
И-мэйл: wqmprogram@asiafound.mn

© 2008, Азийн Сан, зохиогчийн эрхээр хамгаалагдсан.
Анхны хэвлэл, Улаанбаатар хот 2007
Гэрэл зургуудийг Азийн Сан болон Консервейшн Инк/Тэд Вууд.